

Засгийн газрын 2017 оны ... дугаар  
тогтоолын хавсралт

**ГАЗРЫН ТОСНЫ БҮРТГЭЛ, ТООЦООНЫ ЖУРАМ**

Улаанбаатар хот

2017 он

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1. Энэхүү журмын зорилго нь “Газрын тосны тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд газрын тостой холбогдсон үйл ажиллагааг бүртгэх, тооцох, тайлагнах арга зүйг тодорхойлох, зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журмыг “Газрын тосны тухай хууль” болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн салбарын онцлогт тохируулан боловсруулсан болно.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХАМРАХ ХҮРЭЭ**

2.1. Энэхүү журам нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжид хамаарна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. НЭР ТОМЪЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР**

3.1. Үр ашигтай нээлт гэж тухайн үеийн техник, технологийн түвшинд ашиглахад эдийн засгийн үр ашигтай газрын тосны хуримтлал бүхий хураагуурыг;

3.2. Эдийн засгийн үр ашигтай газрын тосны хуримтлал гэж Хайгуул, үнэлгээний үе шатанд Газрын тосны орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр тухайн талбайн газрын тосны талбайд тогтоосон нөөц нь эдийн засгийн үр ашигтай байх хуримтлалыг;

3.3. Газрын тосны үйл ажиллагааны нийтлэг зардал гэж газрын тосны хайгуул, бүтээн байгуулалт, олборлолт, татан буулгалтын үе шатуудад гарсан захиргааны зардлаас бусад өртөг нөхөгдөх зардлыг;

3.4. Хайгуулын ажлын зардал гэж газрын тосны орд нээж, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор гүйцэтгэх геологи, геохими, геофизик, өрөмдлөг, олборлолтын туршилтын ажилтай холбогдон гарах зардлыг;

3.5. Бүтээн байгуулалтын зардал гэж олборлолтын байгууламж, дамжуулах хоолой, дэд бүтцийг хүргэлтийн цэг хүртэл барихтай холбогдон гарах зардлыг;

3.6. Татан буулгалтын зардал гэж бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаа дуусгавар болох үед гэрээлэгч эсхүл оператор компаниас байгаль орчныг бүрэн гүйцэд нөхөн сэргээх, олборлолтын цооногийг хаах, барилга байгууламжийг татан буулгах, нүүлгэн шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг;

3.7. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, тусгай зөвшөөрөл олж авах зардал гэж газрын тосыг хайх хууль ёсны эрх олж авахтай холбоотой гарсан бүхий л зардлыг;

3.8. Өртөг нөхөгдөх зардал гэж хайгуул, бүтээн байгуулалт, үйл ажиллагаа, татан буулгалтын зардлын нийлбэрийг;

3.9. Сунгасан гарын зарчим (Армз-ленгф) гэж харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдэж буй үйлдвэрлэл, худалдаа, санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэсэн үнэ нь ийм харилцан хамааралгүй этгээдүүдийн хоорондох ажил гүйлгээний үнээс ялгаатай байвал харьцуулагдах байдлын шинжилгээ хийх болон тооцоолуудын аргуудыг ашиглан бодит үнийг тодорхойлохыг;

3.10. Харилцан хамаарал бүхий этгээд гэж өөрийн салбар нэгж, эзэмшлийн хамааралтай буюу толгой компаниуд болон тэдгээрийн салбар нэгжүүдийг;

3.11. Олборлосон газрын тос гэж гэрээт талбайгаас олборлож, худалдахаар хэмжсэн болон ашигласан нийт тосыг;

3.12. Хяналтын цэг гэж газрын тосны олборлолтын болон борлуулалтын хэмжилтийн талаар маргаан гарсан тохиолдолд түүнийг хянан шалгах зорилгоор Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тогтоосон цэгийг;

3.13. Хүргэлтийн цэг гэж Засгийн газар болон гэрээлэгчид гэрээний дагуу ногдох газрын тосыг худалдан авагчийн байршилд хэмжиж, хуваах цэгийг;

3.14. Хэмжилтийн цэг гэж Засгийн газар болон гэрээлэгчид гэрээний дагуу ногдох газрын тосыг гэрээт талбайд Монгол Улсын нутаг дэвсгэрт хэмжиж, хуваах цэгийг;

3.15. Засгийн газрын төлөөлөгч гэж Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг;

3.16. Баррель гэж 1,01325 барын агаарын даралтын дор Фаренгейтын жаран (60) хэмийн дулаанд буй буюу тийм нөхцөлд тааруулсан 158,987 литрийн хэмжээг;

3.17. Татан буулгалтын төлөвлөгөө гэж бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаа дуусгавар болох цуцлах үед гэрээлэгч эсхүл оператор компаниас байгаль орчныг бүрэн гүйцэд нөхөн сэргээх, барьсан барилга байгууламжийг татан буулгах, нүүлгэн шилжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны дэс дараалал, ажлын төрөл, хэмжээ, хэрэгжүүлэх хугацааг тусгасан баримт бичгийг;

3.18. Гэрээ байгуулсан өдөр гэж төрийн захиргааны төв байгууллагаас хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон өдрийг;

3.19. Гэрээт жил гэж Гэрээ байгуулсан өдөр буюу дараагийн жилийн уг өдрөөс эхлэн тооцсон дараалсан хуанлийн 12 (арван хоёр) сарын хугацааг;

- 3.20. Гэрээт талбай гэж бүтээгдэхүүн хуваах гэрээнд тодорхойлсон талбайг; Гэрээт талбайн хэмжээ нь буцаасан талбайн хэмжээгээр өөрчлөгдөнө.
- 3.21. Талбай буцааж өгөх гэж бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Гэрээлэгчээс сайн дураар буюу гэрээний дагуу гэрээт талбайг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн буцаахыг;
- 3.22. Төлөвлөгөө гэж газрын тосны эрэл, хайгуул, ашиглалт, татан буулгалтын үе шатанд хийгдэх ажлыг;
- 3.23. Төсөв гэж төлөвлөгөөний мөнгөн илэрхийллийг;
- 3.24. Хайгуулын ажлын доод хэмжээ гэж гэрээлэгч эсхүл оператор компани нь бүтээгдэхүүн хуваах гэрээнд зааснаас багагүй хэмжээний хайгуулын ажлыг гэрээт талбайд жил бүр хийж гүйцэтгэхийг;
- 3.25. Хуанлийн сар гэж аргын тооллын 12 (арван хоёр) сарын 1 (нэг) нь бөгөөд энэ нь тухайн сарын эхний өдрөөс эхлэн, сүүлчийн өдрийг дуустал үргэлжлэхийг;
- 3.26. Хуанлийн улирал гэж а/.нэг, хоёр, гурав дугаар сарууд; б/.дөрөв, тав, зургадугаар сарууд; в/.долоо, найм, есдүгээр сарууд; г/.арав, арван нэг, арван хоёр дугаар сарууд зэрэг аргын тооллын улирлын нэгийг;
- 3.27. Хуанлийн жил гэж аргын тооллын 1 дүгээр сарын 1-нд эхэлж, 12 дугаар сарын 31-нд дуусах 1 (нэг) жилийг;
- 3.28. Санхүүгийн жил гэж аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлангийн жил буюу тухайн оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон хугацааг;
- 3.29. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт/Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (НББОУС/СТОУС) гэж Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс батлан гаргасан стандарт болон тайлбаруудыг хэлнэ.
- 3.30. Дээр дурдснаас бусад нэр томъёог Газрын тосны тухай хуульд хэрэглэсэн утгаар ойлгоно.

### **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ГАЗРЫН ТОСНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛД ТУСГАХ, ТАЙЛАГНАХ**

- 4.1. Газрын тосны үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн зорилгоор дараах үе шатуудад хуваана. Үүнд:
- I үе шат: Эрлийн үе шат
  - II үе шат: Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, тусгай зөвшөөрөл олж авах үе шат

- III үе шат: Хайгуулын үе шат
- IV үе шат: Бүтээн байгуулалтын үе шат
- V үе шат: Олборлолтын үе шат
- VI үе шат: Татан буулгалтын үе шат

## 4.2. I ҮЕ ШАТ: ЭРЛИЙН ҮЕ ШАТ

### 4.2.1. Үйл ажиллагааны хамрах хүрээ:

4.2.1.1. Эрлийн үе шатанд газрын тосны хуримтлал бүхий талбайг ялгах, түүний хэтийн төлөвийг тодорхойлж, цаашид хайгуулын ажил хийх эсэхийг тодорхойлно.

4.2.1.2. Газрын тосны эрлийн ажлыг Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай “эрлийн ажил гүйцэтгэх гэрээ” байгуулснаар эхлүүлнэ.

4.2.1.3. Эрлийн ажлын үр дүнд үндэслэн аж ахуйн нэгж нь бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах хүсэлт гаргаснаар эзэмшлийн үе шатанд шилжинэ.

### 4.2.2. СТОУС-ын дагуу бүртгэх:

4.2.2.1. Эрлийн үе шатанд гарсан зардлуудыг НББОУС 16 *Үндсэн хөрөнгө*, НББОУС 38 *Биет бус хөрөнгө* стандартуудад тодорхойлсон шаардлагатай нийцэж байвал хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үүнд:

Аж ахуйн нэгжийн өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болсон бөгөөд ирээдүйн эдийн засгийн үр өгөөж өгөхөөр хүлээгдэж байгаа бол,

Тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн үр өгөөжийг аж ахуйн нэгж хүртэх магадлалтай, мөн хөрөнгийн өртгийг бодитойгоор хэмжих боломжтой бол.

Холбогдох журналын бичилт:

Дт: Холбогдох биет хөрөнгө/ биет бус хөрөнгө .....xxxx

Кт: Мөнгөн хөрөнгө/ Өр төлбөр .....xxxx

4.2.2.2. Дээрхээс бусад тохиолдолд хайгуулын өмнөх үе шатанд гарсан зардлыг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрч, дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Холбогдох журналын бичилт:

Дт: Зардлын данс .....xxxx

Кт: Мөнгөн хөрөнгө/ Өр төлбөр .....xxxx

### 4.2.3. БХГ-ний дагуу бүртгэх

Эрлийн үе шатанд гарсан бүхий л зардал өртөг нөхөгдөх зардалд хамаарахгүй.

### **4.3. II ҮЕ ШАТ: ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭ БАЙГУУЛАХ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛЖ АВАХ ҮЕ ШАТ**

#### **4.3.1. Үйл ажиллагааны хамрах хүрээ:**

4.3.1.1. Эрлийн ажлын үр дүнд болон сонгон шалгаруулалтын үндсэн дээр холбогдох зөвшөөрлийн дагуу газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, хайгуулын тусгай зөвшөөрөл олж авахтай холбоотой үйл ажиллагааг энэ үе шатанд хамруулна.

4.3.1.2. Энэ үе шатанд газрын тос хайх тусгай зөвшөөрлийг олж авахтай шууд холбогдон гарсан бүхий л зардлууд болон бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулахтай холбоотой зардлууд орно.

4.3.1.3. Эрлийн ажлын үр дүнгээр бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах хүсэлт гаргасан аж ахуйн нэгж нь Гэрээлэгч эсхүл оператор компанийг сонгон шалгаруулах журамд тавигдах шаардлагыг хангасан байна.

4.3.1.4. Аж ахуйн нэгжийн Газрын тосны тухай хуульд зааснаар бүтээгдэхүүн хуваах гэрээний эрх, үүргийг бүхлээр нь, эсхүл гуравны нэг буюу түүнээс дээш хувийг Засгийн газрын зөвшөөрөлтэйгээр шилжүүлэхтэй холбоотой зардал хамаарна.

#### **4.3.2. СТОУС-ын дагуу бүртгэх:<sup>1</sup>**

4.3.2.1. Аж ахуйн нэгж нь Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, тусгай зөвшөөрөл олж авах үе шатанд гарсан зардлуудыг НББОУС 38 *Биет бус хөрөнгө* стандартын дагуу хөрөнгөөр бүртгэх шаардлага хангасан бол тусгай зөвшөөрөл тус бүрээр хуримтлуулан хөрөнгөөр бүртгэж, Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгөөр тайлагнана. Хөрөнгө хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй бол холбогдох зардлаар бүртгэж, Дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

4.3.2.2. Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөрт тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйлчилгээний хөлс, тусгай зөвшөөрөл худалдаж авсан үнэ, тусгай зөвшөөрлийн төлбөр орох ба тусгай зөвшөөрөл бүрээр Хайгуулын тусгай зөвшөөрөл дансанд бүртгэж, Санхүүгийн байдлын тайланд Биет бус хөрөнгөөр тайлагнана. Хайгуулын тусгай зөвшөөрөл дансыг тусгай зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаагаар элэгдүүлэх ба байгуулсан хорогдлын дүнгээр Хайгуул үнэлгээний хөрөнгөнд капиталжуулна.

Холбогдох журналын бичилт:

---

<sup>1</sup> НББОУС 8.10-д тухайн ажил гүйлгээнд дагаж мөрдөх СТОУС байхгүй нөхцөлд удирдлага НББ-ийн бодлогоо санхүүгийн тайлангуудын мэдээллийг хэрэглэгчдэд илүү хамааралтай, итгэл үнэмшилтэй байх зарчмаар боловсруулна гэж заасан.

а. Хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр төлөх үеийн бүртгэл:

Дт: Биет бус хөрөнгө- Хайгуулын тусгай зөвшөөрөл .....xxxx

Кт: Мөнгөн хөрөнгө/ Өр төлбөр .....xxxx

б. Хайгуулын тусгай зөвшөөрөл дансыг тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаагаар элэгдүүлэх үеийн бүртгэл:

Дт: Хайгуул үнэлгээний хөрөнгө .....xxxx

Кт: Биет бус хөрөнгө- Хайгуулын тусгай зөвшөөрөл.....xxxx

4.3.2.3. Хайгуулын ажил нь хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаанаас өмнө дуусаж ашиглалтын тусгай зөвшөөрөл авах тохиолдолд хайгуулын тусгай зөвшөөрлийг хорогдуулж дуусаагүй үлдэгдлийг “Хайгуул үнэлгээний хөрөнгө” дансанд бүртгэнэ.

#### **4.3.3. БХГ-ний дагуу бүртгэх**

4.3.3.1. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах, тусгай зөвшөөрөл олж авах үе шатанд гарсан бүхий л зардал өртөг нөхөгдөх зардалд хамаарахгүй.

### **4.4. III ҮЕ ШАТ: ХАЙГУУЛЫН ҮЕ ШАТ**

#### **4.4.1. Үйл ажиллагааны хамрах хүрээ:**

4.4.1.1. Хайгуулын үе шатанд газрын тосны орд нээж, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор тухайн гэрээт талбайд хайгуул хийсэн түүхэн мэдээ баримтыг олж судлах, дэлгэрэнгүй дүн шинжилгээ хийх; геохими, геофизик, геологийн судалгаа, өрөмдлөг хийх, үнэлгээ, олборлолтын туршилтын ажил хамаарна.

4.4.1.2. Хайгуулын үе шатны үнэлгээ нь үнэлгээний хөтөлбөрөөр үр ашигтай нээлт эсэхийг тогтоох, нөөцийн үнэлгээг тусгасан үнэлгээний ажлын тайлан, орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөг бэлтгэх, батлуулах, хөндлөнгийн шинжээчээр дүгнэлт гаргуулах зэрэг ажлуудыг хамруулна.

4.4.1.3. Тооцоологдсон нөөцөд тулгуурлан тус газрын тосны талбайн эдийн засгийн үр өгөөжийг тооцох ба тооцооллын үр дүнд ашигтай байх тохиолдолд цаашид бүтээн байгуулалт хийх, олборлолт явуулах шийдвэрийг дэд бүтэц, байгаль орчны асуудлаар холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас гаргуулна.

#### **4.4.2. СТОУС-ын дагуу бүртгэх:**

4.4.2.1. Аж ахуйн нэгж нь газрын тосны нөөцийн хайгуул ба үнэлгээтэй холбоотой гарсан зардлуудыг НББОУС 16 *Үндсэн хөрөнгө* стандарт, НББОУС 38

Биет бус хөрөнгө стандартуудад тодорхойлсон шаардлагатай нийцэж байвал хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

4.4.2.2. Хайгуул ба үнэлгээтэй холбоотой тайлант үед гарсан зардлыг хуримтлуулан бүртгэх буюу капиталжуулан, “Хайгуул, үнэлгээний хөрөнгө” дансанд бүртгэн, санхүүгийн байдлын тайлангийн эргэлтийн бус хөрөнгийн хэсэгт тайлагнана. Хайгуул, үнэлгээний хөрөнгийг өртгөөр нь бүртгэнэ.

Холбогдох журналын бичилт:

Дт: Хайгуул үнэлгээний хөрөнгө .....xxxx

Кт: Мөнгөн хөрөнгө/ Өр төлбөр .....xxxx

4.4.2.3. Олборлолтын туршилт эхэлсэн өдрөөс олборлолтын туршилтыг дуусах өдөр хүртэлх хугацаанд гарсан холбогдох зардлыг бүртгэнэ.

4.4.2.4. Олборлолтын туршилтаар олборлосон түүхий тосыг борлуулсан бол холбогдох зардлыг орлоготой нь уялдуулан дэлгэрэнгүй орлогын тайланд зардлаар тайлагнана.

4.4.2.5. Хайгуул ба Үнэлгээний үе шаттай холбоотой гарсан дараах шууд зардлуудыг Хайгуул үнэлгээний хөрөнгөнд хуримтлуулан бүртгэнэ. Тухайлбал: Хайгуул ба Үнэлгээний үе шатанд дурдсан геохимийн судалгаа, геофизикийн судалгаа, өрөмдлөг, лабораторийн ажил, дээж авах, мөн хайгуул ба үнэлгээтэй шууд хамааралтай ажилчдын тэтгэмж, ашигласан материал, шатахуун, судалгаа болон өрөмдлөгийн зардал, гэрээт талуудад төлсөн төлбөр холбоотой гэх мэт үйл ажиллагаатай холбоотой зардлууд.

4.4.2.6. Хоёр буюу түүнээс дээш гэрээт талбайд үйл ажиллагаа явуулдаг гэрээлэгч эсхүл оператор компани нь гэрээт талбай тус бүрээр тодорхойлох боломжгүй нийлмэл зардлыг гэрээт талбай тус бүрээр хуваарилан Хайгуул үнэлгээний хөрөнгөнд бүртгэнэ. Нийлмэл зардлыг хуваарилахдаа гэрээлэгч эсхүл оператор компани нь өөрсдийн онцлогт тохирсон зардлын хуваарилалтын суурийг мөрдөх ба НББ-ийн бодлогод тусгана.

4.4.2.7. Газрын тосны хайгуулын ажлын явцад бэлтгэл ажиллагаа, хугацаа шаардах хөрөнгөнд шууд хамааралтай авсан зээлийн зардлыг капиталжуулах ба НББОУС 23 “Зээлийн зардал”-стандартын дагуу бүртгэнэ.

4.4.2.8. Хайгуул ба үнэлгээний хөрөнгийг хүлээн зөвшөөрсний дараа байгууллага өртгийн загвар эсвэл дахин үнэлгээний загварын аль алиныг ашиглана. Хэрэв дахин үнэлгээний загварыг ашиглаж байгаа бол (НББОУС 16 Үндсэн хөрөнгө эсвэл НББОУС 38-д заасан загварын аль аль нь) уг стандартуудад заасан хөрөнгийн ангилалтай нийцэж байх ёстой.



4.4.2.9. Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа үндсэн хөрөнгийг түүний бодит үнэ цэнийг илтгэх дахин үнэлсэн дүнгээр хэмжих ба дахин үнэлсэн дүн нь дараа үеийн хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байна. Дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрт дахин үнэлгээг хийнэ.

4.4.2.10. Хөрөнгө гэж хүлээн зөвшөөрсний дараа үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан өртгөөр нь үнэлэх ёстой.

4.4.2.11. Хайгуул ба Үнэлгээний хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг бодит нөхцөл байдлууд нь хөрөнгийн дансны үнэ нь тэдгээрийн нөхөгдөх дүнгээс хэтэрсэн байж болзошгүйг илтгэж байвал уг хөрөнгөнд үнэ цэнийн бууралт бий болсон эсэхийг үнэлнэ. Үнэ цэнэ нь буурсан байж болзошгүй хөрөнгийг илрүүлэх шалгалтыг хамгийн багадаа жилд нэг удаа хийх ба шалгалтын давтамжийг аж ахуйн нэгж нягтлан бодох бүртгэлийн бодлогоороо тодорхойлно. Хөрөнгийн үнэ цэнийн бууралтын алдагдлыг НББОУС 36 *Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт*-ын дагуу бүртгэнэ.

4.4.2.12. Дор дурдсан бодит нөхцөл байдлуудаас нэг эсвэл хэд хэдэн нөхцөл биелбэл Хайгуул үнэлгээний хөрөнгөнд үнэ цэнийн бууралтын шалгалт хийнэ. Үүнд:

- Гэрээт талбайд хайгуул хийх эрхийн хугацаа нь хайгуулын явцад дууссан эсвэл ойрын хугацаанд дуусах бөгөөд дахин шинэчлэгдэх боломжгүй, хугацааг сунгахаар төлөвлөгдөөгүй;
- Тухайн газар нутагт цаашид газрын тосны Хайгуул ба Үнэлгээний ажлыг үргэлжлүүлэн хийх томоохон зардлууд нь төсөв болон төлөвлөгөөнд тусгагдаагүй;
- Тухайн газар нутагт хийсэн газрын тосны хайгуул болон үнэлгээгээр арилжааны үр ашиг өгөхүйц хэмжээний газрын тосны нөөцийг илрүүлээгүй тул байгууллагын зүгээс тухайн газарт хийх үйл ажиллагааг зогсоохоор шийдсэн;
- Бүтээгдэхүүний үнэ буурах эсвэл үйлдвэрлэлийн зардал өсөх;
- Засгийн газрын зүгээс байгаль орчны хуулийг шинээр батлах, үнэ бүрдэлтийн зохицуулалт хийх болон татварыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авах.
- Стандартад заасан дээрх нөхцөлөөс гадна бүртгэлийн бодлогодоо тодорхойлсон өөр шалгуурыг авч үзэж болно.

4.4.2.13. Үнэ цэнийн бууралтын алдагдлыг буцаах:

4.4.2.13.1. Хамгийн сүүлд үнэ цэнийн гарзыг хүлээн зөвшөөрснөөс хойш хөрөнгийн нөхөгдөх дүнг тодорхойлоход хэрэглэсэн тооцоололд өөрчлөлт орсон бол өмнөх үед хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын гарзыг буцаана. Үнэ цэнийн алдагдлын гарзыг буцаасны улмаас өсөх хөрөнгийн дансны үнэ нь үнэ цэнийн бууралт хүлээн зөвшөөрөөгүй байх үеийн дансны үнээс хэтрэх ёсгүй.

4.4.2.13.2. НББОУС 36 *Хөрөнгийн Үнэ Цэнийн Бууралт* стандартын 109-123-р зүйлд заасан тусгай шаардлагуудад нийцэж байгаа үед аж ахуйн нэгжийн бүх хөрөнгө (гүүдвил болон борлуулахад бэлэн гэж ангилсан өмчийн хөрөнгө оруулалтаас бусад)-ийн хувьд үнэ цэнийн бууралтын гарзыг буцаана.

4.4.2.13.3. Хэрэв хайгуул, үнэлгээний хөрөнгөнд үнэ цэнийн бууралт тооцсон эсвэл шалгалтаар үнэ цэнийн бууралт байхгүй бол хайгуул үнэлгээний хөрөнгийн дахин ангилал хийнэ.

4.4.2.14. Хайгуул үнэлгээний хөрөнгийн дахин ангилал: Газрын тосны нөөцийг олборлох орд ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө ба арилжааны үр ашиг нь тодорхой болсон, тухайн ордыг арилжааны зорилгоор ашиглах шийдвэр гарсан үед Хайгуул үнэлгээний хөрөнгийг Газрын тосны хөрөнгөөр шилжүүлэн бүртгэнэ.

Холбогдох журналын бичилт:

Дт: Газрын тосны хөрөнгө .....xxxx

Кт: Хайгуул үнэлгээний хөрөнгө .....xxxx

4.4.2.15. Газрын тосны нөөцийн орд ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө ба арилжааны үр ашигт үндэслэн үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх эсэхийг удирдлага шийдвэрлэнэ. Хэрэв тухайн нэг тусгай зөвшөөрлийн эсвэл нийтэд нь хайгуулын ажлыг зогсоох шийдвэр гаргавал хуримтлуулан бүртгэсэн Хайгуул, үнэлгээний хөрөнгийг тухайн тайлант үеийн алдагдлаар хүлээн зөвшөөрч, амжилтгүй хайгуулын зардал дансанд хааж, дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана.

Холбогдох журналын бичилт:

Дт: Амжилтгүй хайгуулын зардал .....xxxx

Кт: Хайгуул үнэлгээний хөрөнгө .....xxxx

4.4.2.16. Тухайн тайлант өдрийн дараа хийгдсэн өрөмдлөгийн үйл ажиллагаагаар олж илрүүлсэн баримт нотолгооны үр дүнд амжилтгүй болох нь тогтоогдвол энэ үйл явдлыг санхүүгийн тайланд тодруулна. Үүнийг НББОУС 10 *“Тайлагналын үеийн дараах үйл явдал”* стандартын дагуу зохицуулна. Тус стандартаар санхүүгийн тайланг залруулах, болон үл залруулах буюу тодруулах үйл явдлыг тодорхойлсон. Үүнд:

4.4.2.16.1. Тайлагналын өдрийн дараах залруулагдах үйл явдал буюу санхүүгийн тайланг залруулах, өөрөөр хэлбэл залруулга хийх шаардлагатай үйл явдлууд гэдэгт тайлагналын хугацааны эцэст тухайн нөхцөл үүссэнийг нотлох баримт, нотолгоо байгаа үйл явдлууд хамаарна.

4.4.2.16.2. Тайлагналын өдрийн дараах үл залруулагдах үйл явдал буюу санхүүгийн тайланд тодруулах, өөрөөр хэлбэл нөхцөл байдал нь тайланг тасалбар болгосноос хойш буюу тайланг бэлтгэсний дараа үүссэн бол тухайн үйл явдал нь залруулга хийх шаардлагагүй нөхцөл байдалд хамаарна.

4.4.2.17. Гэрээлэгч эсхүл оператор компани нь санхүүгийн тайландаа хүлээн зөвшөөрсөн газрын тосны хайгуул ба үнэлгээтэй холбоотой дүнг тодорхойлж, тайлбарласан нэмэлт тодруулга хийнэ. Үүнд:

- Хайгуул, үнэлгээний хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт болон түүний зарцуулалтын талаарх нягтлан бодох бүртгэлийн бодлого;
- Газрын тосны нөөцийн хайгуул, үнэлгээтэй холбоотой бий болсон хөрөнгө, өр төлбөр, орлого ба зардал, үйл ажиллагааны ба хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний дүн;
- Хайгуул, үнэлгээний хөрөнгийг тусдаа хөрөнгийн ангилалд тусгах бөгөөд НББОУС 16 эсвэл НББОУС 38-д шаардсаны дагуу тэдгээр хөрөнгийг хэрхэн ангилсан тухай тодруулга;
- Бусад холбоотой стандарт шаардлагуудын дагуу тодруулга хийх;

#### **4.4.3. БХГ-ний дагуу бүртгэх:**

4.4.3.1. Хайгуулын ажилтай холбогдон гарсан дараах зардлууд нь өртөг нөхөгдөх зардалд хамаарна. Үүнд:

- Газрын тосны орд нээж, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор гүйцэтгэхэд холбогдон гарах геологи, геохими, геофизик, өрөмдлөг, олборлолтын туршилтын ажлын зардлууд,
- Хээрийн ангийн зохион байгуулалт, гэрээт талбай дахь ажиллагсдын ажиллах, амьдрах нөхцлийг хангахтай холбоотой болон хайгуулын үйл ажиллагаатай холбогдон гарах нийтлэг зардлууд,
- Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хайгуулын цооногийн өрөмдлөгийн даалгаврыг биелүүлсэн гэж үзсэн тохиолдолд өрөмдлөгийн зардлыг өртөг нөхөх зардлууд,

4.4.3.2. Энэ үе шатанд төлсөн Монгол Улс болон бусад улсад төлсөн татвар, хураамж, тусгай зөвшөөрлийн төлбөр болон урамшуулал, үйлчилгээний хөлс бусад төлбөр нь өртөг нөхөгдөх зардалд хамаарахгүй.

4.4.3.3. Газрын тосны үйл ажиллагааны нийтлэг зардлуудыг өртөг нөхөгдөх зардалд оруулах эсэхийг энэхүү журмын 4.9.1 болон 4.9.2-р зохицуулна.

4.4.3.4. Хайгуул үнэлгээний хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл болон үнэ цэнийн бууралтын алдагдал нь өртөг нөхөгдөх зардалд хамаарахгүй.

#### 4.5. IV үе шат: Бүтээн байгуулалтын үе шат

##### 4.5.1. Үйл ажиллагааны хамрах хүрээ:

4.5.1.1. Орд ашиглалтын төлөвлөгөөг тооцож дуусах, үр ашигтай нээлт болохыг тогтоож, бүтээн байгуулалтын үе шатыг эхлүүлэх дэд бүтэц, байгаль орчны асуудлаар холбогдох төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авсан үеэс эхлэн шилжсэн гэж үзнэ.

4.5.1.2. Гэрээт талбайд хэвийн олборлолт эхлэхээс өмнө бүтээн байгуулалтын үе шатанд хөрөнгийн болон үйл ажиллагааны шинжтэй газрын тосыг тээвэрлэх, дамжуулах хоолой болон дэд бүтэц барих, машин тоног төхөөрөмж суурилуулах, үйлдвэрлэлийг явуулахад шаардлагатай бусад бэлтгэл ажлууд хамаарна.

##### 4.5.2. СТОУС-ын дагуу бүртгэх:

4.5.2.1. Гэрээт талбайгаас хэвийн олборлолт хийж эхэлснээс хойш талбайг үргэлжлүүлэн бүтээн байгуулах, газрын тосны олборлолт хийхтэй холбоотой хөрөнгийн шинжтэй томоохон зардлуудыг НББОУС 16 Үндсэн хөрөнгө стандартын дагуу бүртгэлд тусгана.

4.5.2.2. Бүтээн босгох үе шатанд хийгдэж буй дэд бүтцийн зардлуудыг бий болгож буй биет хөрөнгийг ангиллын дагуу Дуусаагүй барилга дансанд хуримтлуулан бүртгэнэ. Дуусаагүй барилга дансанд хөрөнгийн ангиллын дагуу туслах дансыг нээж болно.

Дт Дуусаагүй барилга .....xxxx  
Кт Мөнгө/ Өр төлбөр .....xxxx

4.5.2.3. Хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үед Дуусаагүй барилга данснаас холбогдох биет хөрөнгө (барилга байгууламж, тоног төхөөрөмж гэх мэт)-өөр ангилах ба хөрөнгийг элэгдүүлнэ:

Дт Холбогдох үндсэн хөрөнгө .....xxxx  
Кт Дуусаагүй барилга .....xxxx

4.5.2.4. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг олборлох үе шат хүртэл Газрын тосны хөрөнгө дансанд капиталжуулан бүртгэнэ.

Дт Газрын тосны хөрөнгө .....xxxx  
Кт Мөнгө/ Өр төлбөр .....xxxx

4.5.2.5. Олборлох үе шатанд төлсөн ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг бүтээгдэхүүний өртөгт бүртгэнэ.

4.5.2.6. Бүтээн байгуулалтын үед гарсан нийтлэг зардлыг холбогдох бүтээн байгуулалтын өртөгт шингээж, дуусаагүй барилга дансанд капиталжуулна.

4.5.2.7. Зээлийн өртөг: Аж ахуйн нэгж нь зээлийн өртгийг НББОУС 23 Зээлийн өртөг стандартын дагуу тайлагнана. Бэлтгэл шаардах хөрөнгө буюу зориулалтын дагуу ашиглахад ихээхэн хэмжээний хугацаа зайлшгүй шаардагддаг хөрөнгийг олж бэлтгэх, барилгын ажил болон үйлдвэрлэлтэй шууд хамааралтай зээлийн өртгийг тухайн хөрөнгийн өртөгт капиталжуулна. Бусад зээлийн өртгийг зардалд бүртгэн тайлант үеийн ашиг, алдагдалд тусгана.

4.5.2.8. Дараах нөхцлүүдийг бүгдийг нь хангасан өдрөөс эхлэн хүүг капиталжуулж эхэлнэ.

4.5.2.8.1. аж ахуйн нэгж бэлтгэл шаардах хөрөнгөнд зардал гаргасан,

4.5.2.8.2. зээлийн өртөг үүссэн болон,

4.5.2.8.3. хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад бэлтгэх шаардлагатай үйл ажиллагааг эхлүүлсэн.

4.5.2.9. Зориулалтын дагуу ашиглах эсвэл борлуулах хөрөнгийг бэлтгэхэд шаардагдах бүх ажиллагаа дууссан үед зээлийн өртгийн капиталжуулалтыг зогсооно.

4.5.2.10. Бэлтгэл шаардагдах хөрөнгийн барилгын ажил хэсэгчлэн дууссан үед хэсэг бүрийг тухайн үед ашиглаж болох боловч бусад хэсгийн барилгын ажил үргэлжлэн хийгдэж байгаа үед зориулалтын дагуу ашиглах эсвэл борлуулах тэр хэсгийг бэлтгэхэд шаардагдах үндсэн ажиллагаа дууссан нөхцөлд зээлийн өртгийн капиталжуулалтыг зогсооно.

4.5.2.11. Бүтээн байгуулалтыг түр зогсоох тухай шийдвэр гаргасан тохиолдолд хүүгийн капиталжуулалтыг түр зогсоож болох ба энэ үед хүүгийн зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд санхүүгийн зардлаар хүлээн зөвшөөрнө.

4.5.2.12. Капиталжуулах зээлийн өртгийн дүнг тооцоолохдоо байгууллагын ерөнхий зээлийн жигнэсэн дундаж (бэлтгэл шаардах хөрөнгөнд зарцуулсан зардлыг жигнэсэн дундаж хүүгийн өртгөөр үржүүлэн гаргасан дүн) өртгийг ашиглан тооцоолно.

### 4.5.3. БХГ-ний дагуу бүртгэх:

4.5.3.1. Гэрээт талбайгаас олборлосон тосыг хүргэлтийн цэг хүртэл тээвэрлэх зориулалт бүхий дамжуулах хоолой болон дэд бүтэц, шаардлагатай бусад байгууламжийг барьж байгуулах зардлууд нь өртөг нөхөгдөх зардалд хамаарна.

4.5.3.2. Бүтээн байгуулалтын ажилтай холбогдон гарах захиргааны бусад зардлыг бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хувиар тооцож, өртөг нөхөгдөх зардалд хамааруулна.

4.5.3.3. Энэ үе шатанд төлсөн Монгол Улс болон бусад улсад төлсөн татвар, хураамж, тусгай зөвшөөрлийн төлбөр болон урамшуулал, үйлчилгээний хөлс бусад төлбөр нь өртөг нөхөгдөх зардалд хамаарахгүй.

4.5.3.4. Нийтлэг зардлуудыг өртөг нөхөгдөх зардалд оруулах эсэхийг энэхүү журмын 4.9.1 болон 4.9.2-р зохицуулна.

## 4.6. V үе шат: Олборлолтын үе шат

### 4.6.1. Үйл ажиллагааны хамрах хүрээ:

4.6.1.1. Газрын тосны гэрээт талбайг ашиглахад бэлэн болж, ашиглалтын тусгай зөвшөөрөл авсан үед олборлолтын үе шатанд шилжинэ.

4.6.1.2. Олборлолтын үе шатанд борлуулалтаас ашиг олохуйц хэмжээний бүтээгдэхүүнийг орд газраас олборлоход чиглэсэн өдөр тутмын үйл ажиллагаа явагдах бөгөөд газрын тосны олборлолт болон борлуулалтын үйл ажиллагаа хамаарна.

4.6.1.3. Олборлолтын үеийн зардалд газрын тос олборлохтой холбогдон гарах үйл ажиллагааны зардал (олборлолтын зардал), нийтлэг зардал, хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн хорогдлын зардал, олборлох үйл ажиллагаатай холбоотой хуримтлуулсан хайгуул, бүтээн байгуулалтын зардлын тайлант үеийн элэгдлийн зардал, олборлосон газрын тосыг төмөр зам, тусгай зориулалтын автомашин, дамжуулах хоолойгоор тээвэрлэх зардлууд хамаарна.

### 4.6.2. СТОУС-ын дагуу бүртгэх:

4.6.2.1. Олборлолт ба бүтээн байгуулалтын үе шатнаас эхлэн Газрын тосны хөрөнгө дансыг олборлосон бүтээгдэхүүний нэгжид үндэслэн хугацаанд хорогдуулна. Хорогдуулалтыг бүртгэхдээ:

Дт Дуусаагүй үйлдвэрлэл .....xxxx

Кт Газрын тосны хөрөнгө .....xxxx

4.6.2.2. Ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх үеийн бүртгэл:

Дт Дуусаагүй үйлдвэрлэл .....xxxx  
Кт Мөнгөн хөрөнгө/ Өр төлбөр .....xxxx

4.6.2.3. Олборлолтын үеийн зардлуудыг дэлгэрэнгүй орлогын тайланд зардал гэж тусгана.

4.6.2.4. Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан төлбөр, урамшуулал, үйлчилгээний хөлсийг тайлант хугацааны зардлаар бүртгэнэ.

Дт: Холбогдох зардлын данс .....xxxx  
Кт: Мөнгөн хөрөнгө/ Өр төлбөр .....xxxx

#### **4.6.3. БХГ-ний дагуу бүртгэх:**

4.6.3.1. Энэ үе шатанд төлсөн Монгол Улс болон бусад улсад төлсөн татвар, хураамж; тусгай зөвшөөрлийн төлбөр болон урамшуулал, үйлчилгээний хөлс бусад төлбөр нь өртөг нөхөгдөх зардалд хамаарахгүй.

4.6.3.2. Газрын тос олборлохтой холбогдон гарсан Үйл ажиллагааны зардал (Олборлолтын зардал) нь өртөг нөхөгдөх зардалд хамаарна.

4.6.3.3. Нийтлэг гарах зардлуудыг өртөг нөхөгдөх зардалд оруулах эсэхийг энэхүү журмын 4.9.1 болон 4.9.2-р зохицуулна.

#### **4.7. VI үе шат: Татан буулгалтын үе шат**

##### **4.7.1. Үйл ажиллагааны хамрах хүрээ:**

4.7.1.1. Татан буулгалтын үе шатанд бүтээгдэхүүн хуваах гэрээний хугацаа дуусгавар болох үед байгаль орчныг бүрэн гүйцэд нөхөн сэргээх, олборлолтын цооногийг хаах, барьсан барилга байгууламжийг татан буулгах, нүүлгэн шилжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг хамруулна.

##### **4.7.2. СТОУС-ын дагуу бүртгэх:**

4.7.2.1. Аж ахуйн нэгж нь хөрөнгийг олж бэлтгэх, барьж байгуулах, бүтээн байгуулах эсвэл хөрөнгийн энгийн үйл ажиллагааны үед түүнийг ашиглалтаас гаргах үүрэг хариуцлага, мөн хүрээлэн буй орчны хэвийн төрхийг алдагдуулах үед түүнийг нөхөн сэргээхтэй холбоотойгоор хуулийн эсвэл гэрээний үүрэг хариуцлага үүсдэг.

4.7.2.2. НББОУС 37 Нөөц, Болзошгүй Өр Төлбөр ба Болзошгүй Хөрөнгө стандартын дагуу Татан буулгалтын нөөц санг байгуулах шалгуур хангагдсан гэж

үзвэл Газрын тосны тухай хуулийн 11.2.9, 11.2.10, 11.2.19-р зүйлд заасны дагуу гэрээлэгч нь байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон хайгуул, ашиглалтын үеийн барилга байгууламжийг татан буулгах нөөц санг байгуулна.

4.7.2.3. Нөөцийг дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө.

4.7.2.3.1. Өнгөрсөн үйл явдлын үр дүнд өнөөгийн үүрэг хариуцлага (хуулийн дагуу эсвэл үүсмэл) хүлээсэн

4.7.2.3.2. Уг үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гарна гэдэг нь магадлалтай болсон

4.7.2.3.3. Үүргийн дүнг найдвартай тооцоолох боломжтой

4.7.2.4. Нөөцөөр хүлээн зөвшөөрөх дүн нь тайлангийн өдрөөрх өнөөгийн үүрэг хариуцлагыг биелүүлэхэд шаардлагатай зарлагын хамгийн сайн тооцоолол байх ёстой. Өөрөөр хэлбэл, аж ахуйн нэгж нь тайлангийн өдрөөр тухайн үүргийг биелүүлэх эсвэл зохих ёсоор гуравдагч талд шилжүүлэхийн тулд төлөх дүн байна.

4.7.2.5. Нөөцийг буцаахдаа үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад шаардагдах эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гадагшлах магадлал байхгүй болбол нөөцийн дүнг буцаан бичнэ.

4.7.2.6. Нөхөн сэргээлтийн нөөц хүлээн зөвшөөрсөн хөрөнгийг зарсан эсвэл гуравдагч талд шилжүүлсэн болон гэрээ, хууль эрх зүйн өөрчлөлтийн нөлөөгөөр өмнө нь хүчин төгөлдөр байсан хуулийн болон үүсмэл үүрэг хариуцлага нь үгүй болсон тохиолдолд байгуулсан нөөцийг үл хүлээн зөвшөөрнө.

4.7.2.7. Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах нөөцийг Татан буулгалтын хөрөнгөнд хуримтлуулах ба газрын тосны орд газрын ашиглалтын хугацаанд бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргаар хорогдуулна.

4.7.2.8. Орд газрын хаалт ба нөхөн сэргээлтийн санг анх хүлээн зөвшөөрөхдөө:

Дт Татан буулгалтын хөрөнгө .....xxxx  
Кт Татан буулгалтын сан.....xxxx

4.7.2.9. Байгуулсан орд газрын хаалт, нөхөн сэргээлтийн хөрөнгийг газрын тос ашиглалтын хугацаанд бүтээгдэхүүний нэгжид ногдуулан хорогдуулна:

Дт Дуусаагүй үйлдвэрлэл.....xxxx  
Кт Татан буулгалтын хөрөнгө.....xxxx



4.7.2.10. Татан буулгалтын зардал бодитоор гарах үед дараах бичилтийг хийнэ. Үүнд:

Дт Татан буулгалтын сан .....xxxx  
Кт Мөнгө/өр төлбөр.....xxxx

4.7.2.11. Газрын тосны тухай хуулийн 11.2.9-д заасны дагуу байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн эскроу дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг барьцааны хөрөнгө, эсвэл урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ.

#### **4.7.3. БХГ-ний дагуу бүртгэх:**

4.7.3.1. Татан буулгалтын үед бодитоор гарсан зардлыг өртөг нөхөгдөх зардалд хамааруулна.

4.7.3.2. Татан буулгалтын үйл ажиллагаанд Эскроу дансанд байршуулсан татан буулгалтын мөнгөн хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд гэрээлэгч эсхүл оператор компани өөрийн хөрөнгөөр уг үйл ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

4.7.3.3. Нийтлэг гарах зардлуудыг өртөг нөхөгдөх зардалд оруулах эсэхийг энэхүү журмын 4.9.1 болон 4.9.2-р зохицуулна.

4.7.4. Элэгдэл ба хорогдол

4.7.4.1. Үндсэн хөрөнгийн элэгдлийг НББОУС 16 *Үндсэн хөрөнгө* стандартыг дагаж мөрдөнө.

4.7.4.2. Хайгуул ба үнэлгээний үе шатанд үүссэн хөрөнгийг элэгдүүлэхдээ:

4.7.4.3. Биет бус хөрөнгөөр ангилагдсан хөрөнгүүдийг ашиглагдах хугацаагаар нь хорогдол байгуулан Хайгуул үнэлгээний хөрөнгөд бүртгэнэ.

4.7.4.4. Биет хөрөнгө (тухайлбал машин, тоног төхөөрөмж гэх мэт)-ийг ашиглалтын хугацаанд элэгдүүлэн Хайгуул үнэлгээний хөрөнгөд бүртгэнэ.

4.7.4.5. Олборлолт эхлэнгүүт НББ-ийн зорилгоор хайгуул, үнэлгээний хөрөнгөнд элэгдэл, хорогдол тооцож эхлэнэ.

4.7.4.6. Бүтээн байгуулсан болон худалдан авсан хөрөнгийг НББОУС 16-ын дагуу үндсэн хөрөнгөөр, харин биет бус хөрөнгийг НББОУС 38-ын дагуу тус тус бүртгэнэ.

4.7.4.7. Биет болон биет бус хөрөнгийг ашиглалтын хугацааны туршид элэгдүүлэх хугацааг гэрээлэгч эсхүл оператор компани өөрсдийн туршлага, хөрөнгийн онцлогт үндэслэж тогтооно.

#### **4.8. Орлого, санхүүжилтийн бүртгэл**

4.8.1. Гэрээлэгч эсхүл оператор компани нь орлогыг СТОУС 15 *Худалдан авагчтай байгуулсан гэрээнээс орох орлого*-ын дагуу нягтлан бодох бүртгэлд тусгана.

**4.8.2.** Гэрээлэгч эсхүл оператор компанийн газрын тосны үндсэн үйл ажиллагааны орлого нь газрын тосны гэрээт талбай болон хайгуул, үнэлгээний цооногоос туршилтаар олборлосон өртөгт болон ашигт газрын тосыг борлуулсны төлбөрт хүлээн авсан орлого байна.

4.8.3. Гэрээлэгч эсхүл оператор компанийн үндсэн бус орлого нь эд хөрөнгөд учирсан хохирлын улмаас даатгалын гэрээний дагуу олсон орлого (даатгалын шимтгэл нь нөхөн төлөгдөх зардалд тооцогдсон); Газрын тосыг хүргэлтийн цэг хүртэл тээвэрлэх явцад устсан, олсон эсхүл алдагдсаны улмаас даатгалын гэрээний дагуу олсон орлого (даатгалын шимтгэл нь нөхөн төлөгдөх зардалд тооцогдсон) эсхүл гэм хорын нөхөн төлбөр; гэрээлэгч эсхүл оператор компанийн дансанд бүртгэлтэй өртөг нь нөхөгдөх эсхүл нөхөгдсөн аливаа эд материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг салбар байгууллага эсхүл бусад байгууллага, хувь хүнд худалдах, экспортлох, шилжүүлэх, түрээслүүлэх үйл ажиллагаанаас олсон орлого; газрын тосны үйл ажиллагаанаас олсон мэдээллийг борлуулсны орлого; газрын тосны үйл ажиллагааны талаар гарсан заргаас олсон орлого байна.

4.8.4. Гэрээлэгч эсхүл оператор компани нь бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны бүтээгдэхүүний орлогыг хүргэлтийн цэг дээр хэмжиж, хуваах үед орлогоор хүлээн зөвшөөрч, нягтлан бодох бүртгэлд бүртгэнэ.

4.8.5. Талууд газрын тосны үнэлгээг тухайн хуанлийн сарын өмнөх сард дэлхийн зах зээл дээр ижил чанарын тосыг чөлөөт валютаар худалдаалахад хэрэглэсэн үнийн дундаж болон тухайн зах зээлийн байршил, газрын тосны зэрэглэл, чанар, бусад физик шинж чанарыг харгалзан энэхүү журмын 12.9.1-д заасны дагуу тооцно.

4.8.6. Гэрээлэгч эсхүл оператор компани газрын тос борлуулах, тээвэрлэхтэй холбогдсон гэрээний төслийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад урьдчилан танилцуулж, харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээ байгуулна.

4.8.7. Нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт тосны хуваарилалт, хэмжилт, үнэлгээ, тооцоололтой холбоотой зөрүү гарсан тохиолдолд талууд зөрүүг энэ журмын 12.1.1.4-т заасны дагуу тодруулж залруулна.

4.8.8. Гэрээлэгч эсхүл оператор компанийн орлого нь бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан өртөгт болон ашигт газрын тос байна. Өртөгт болон ашигт газрын тосыг тооцохдоо энэхүү журмын 12.11-г баримтална.

4.8.9. Гэрээлэгч эсхүл оператор компани нь өөрт болон Монгол Улсын Засгийн газарт ногдох ашигт газрын тос болон нөөц ашигласны төлбөр, олборлосон газрын тосыг тээвэрлэсэн тээврийн зардал зэргийг бүртгэхдээ:

Дт	Харилцагчаас авах авлага.....xxxx
кт	Тээврийн компанид өгөх өглөг.....xxxx
кт	Нөөц ашигласны төлбөрийн өглөг .....xxxx
кт	ЗГ-т өгөх өглөг - ЗГ-т ногдох ашигт газрын тос.....xxxx
кт	Гэрээлэгчид ногдох ашигт газрын тос .....xxxx
кт	Гэрээлэгчийн орлого-өртөгт газрын тос.....xxxx

#### 4.9. Өртөг нөхөгдөх ба өртөг нөхөгдөхгүй зардал

##### 4.9.1. Өртөг нөхөгдөх зардал

4.9.1.1. Хайгуул, бүтээн байгуулалт, олборлолт, татан буулгалтын үе шатуудад гэрээт талбайд гарсан хөдөлмөр эрхлэлтийн зардал, тоног төхөөрөмжийн худалдан авалт, бараа материалын зардал, тээвэрлэлтийн зардал, үйлчилгээний зардал, харилцаа холбооны зардал, хээрийн анги, агуулах болон бусад байгууламжийн зардал, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал, даатгалын зардал, хууль, эрх зүйн үйлчилгээний зардал, сургалтын зардал болон захиргааны зардлууд (БХГ-нд заасан хувиар) нь өртөг нөхөгдөх зардалд хамаарна.

##### 4.9.1.2. Хөдөлмөр эрхлэлтийн зардал

4.9.1.2.1. Газрын тосны хайгуул, бүтээн байгуулалт, олборлолт, татан буулгалтын үйл ажиллагаанд шууд болон зайлшгүй оролцох гэрээлэгчийн эсхүл оператор компанийн Монгол Улсад байнгын оршин суугч гадаад ажиллагсдын цалин хөлс, урамшуулал, нийтээр тэмдэглэх баярын өдөр ажилласан цалин хөлс, ээлжийн амралтын олговор, хөдөлмөрийн чадвар түр алдах болон тахир дутуугийн нөхөн олговор, амьжиргаа, орон байрны бусад хөнгөлөлт, цалин хөлс болон тэтгэвэр тэтгэмж олгохтой холбогдон гарах зардал, цалин хөлсөд хамааруулж холбогдох хуулийн дагуу ногдуулж байгаа шимтгэл, татвар хураамжийн зардлууд хамаарна.

4.9.1.2.2. Монгол Улсын иргэн болон Монгол Улсад байнгын оршин суугч гадаадын иргэн ажиллагсдад Монгол Улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу олгогдсон гэнэт халагдсаны тэтгэмжийн зардал хамаарна.

##### 4.9.1.3. Машин механизм, тоног төхөөрөмжийн зардал

4.9.1.3.1. Гэрээт талбайд ашиглагдах тусгай зориулалтын машин, тээврийн хэрэгсэл, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, тоноглолыг ашиглалтанд тавьж олгосон үед бодит төлсөн дүнгээр (тээврийн зардал ороогүй) өртөг нөхөгдөх

зардалд тооцно. Тусгай зориулалтын машин, техник хэрэгслийг түрээслэх үед түрээсийн зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцно.

#### 4.9.1.4. Бараа материалын зардал

4.9.1.4.1. Бараа материалд түүхий эд, химийн болон тэсрэх бодис, сэлбэг хэрэгсэл хамаарна. Бараа материалыг ашигласан үед түүний бодит төлсөн үнийн дүнгээр эхэлж авсанаа эхэлж зарлагдах аргачлалаар зардалд бүртгэнэ.

#### 4.9.1.5. Тээвэрлэлтийн зардал

4.9.1.5.1. Тээвэрлэлттэй холбогдон гарах зардалд газрын тосны хайгуул, бүтээн байгуулалт, олборлолт, татан буулгалтын үйл ажиллагаанд шаардлагатай тусгай зориулалтын машин, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, бараа материалыг тээвэрлэхэд гарсан хөрөнгийн өртөгт шингээгүй тээврийн зардлууд хамаарна.

#### 4.9.1.6. Үйлчилгээний зардал

Үйлчилгээний зардалд холбогдон гарах зардалд дараах зардлууд хамаарна. Үүнд:

4.9.1.6.1. Гуравдагч этгээдийн үзүүлсэн үйлчилгээний зардалд гэрээлэгч эсхүл оператор компанид гуравдагч этгээдийн (харилцан хамааралгүй этгээд) үзүүлсэн зөвлөх үйлчилгээ, гэрээт үйлчилгээ болон хангамжийн үйлчилгээний зардал хамаарна.

4.9.1.6.2. Гэрээлэгч эсхүл оператор компанийн харилцан хамаарал бүхий этгээдийн үзүүлсэн үйлчилгээний зардалд Монгол Улсад болон хилийн чанадад лабораторийн шинжилгээ хийх, загварчлах, геологи, геофизикийн боловсруулалт, тайлал хийх, инженерийн болон мэдээлэл боловсруулах зэрэг үйлчилгээний зардал хамаарна.

4.9.1.6.3. Гэрээлэгч эсхүл оператор компанийн харилцан хамаарал бүхий этгээдээс үзүүлсэн үйлчилгээ нь бодит үнээс ялгаатай бол “Сунгасан гарын зарчим”-ыг баримтлана.

#### 4.9.1.7. Харилцаа холбооны зардал

4.9.1.7.1. Гэрээт талбайд ашиглах радио, бичил долгионы төхөөрөмж зэрэг харилцаа холбооны системийг худалдан авах, түрээслэх, суурилуулах, ажиллуулах, засварлах, арчлахтай холбогдон гарах зардал хамаарна;

#### 4.9.1.8. Хээрийн анги, агуулах болон бусад байгууламжийн зардал

4.9.1.8.1. Гэрээлэгч эсхүл оператор компанийн газрын тосны хайгуул, ашиглалтын талбай дахь албан контор, агуулах, архив, орон байр болон бусад байгууламжийг барих, арчлах, ашиглах бодит зардлууд хамаарна.

4.9.1.9. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал

4.9.1.9.1. Гэрээлэгч эсхүл оператор компанийн газрын тосны хайгуул, ашиглалтын гэрээт талбайд гарсан түүх соёлын олдвор, эд өлгийн зүйл бүхий газрыг тогтоох, хамгаалах, археологийн судалгаа хийх зардал, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал, дэвшилтэд тоног төхөөрөмжийн зардал, байгаль орчны үнэлгээ, хяналт, шинжилгээ, бусад судалгааны зардлууд хамаарна.

4.9.1.10. Даатгалын зардал

4.9.1.10.1. Гэрээлэгч эсхүл оператор компани нь газрын тосны хайгуул, ашиглалт, бүтээн байгуулалт, татан буулгалтын үйл ажиллагаа болон эд хөрөнгийг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын даатгалын компаниар даатгуулж болно. Хэрэв Монгол Улсын даатгалын эрх бүхий компани нь даатгалыг хийхээс татгалзсан тохиолдолд гэрээлэгч, оператор компани нь төрийн захиргааны байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр гадаад улсын даатгалын хуулийн этгээдээр даатгуулж, гэрээний дагуу төлсөн даатгалын зардлыг өртөг нөхөгдөх зардалд хамруулна.

4.9.1.11. Хууль эрх зүйн үйлчилгээний зардал

4.9.1.11.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гэрээлэгч эсхүл оператор компанийн газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд шууд хамаарах асуудлаар үүссэн аливаа маргааныг шүүхээр шийдвэрлэх,

4.9.1.11.2. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаатай холбогдуулан аливаа гуравдагч этгээдээс гаргасан гомдлыг шийдвэрлэхтэй холбогдуулан гарах зардал,

4.9.1.11.3. Төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч эсхүл оператор компани нэгдмэл сонирхлоо хамгаалах шаардлагаар авсан хууль зүйн үйлчилгээний зардал,

4.9.1.11.4. Өмгөөлөгчийн хөлс, шүүхийн зардал, гомдол, нэхэмжлэлийг судлах, нотлох баримт цуглуулахад гарсан зардал (гэрээлэгч эсхүл оператор компанийн хувь эзэмшигч, хөрөнгө оруулагч, туслан гүйцэтгэгч нарын хооронд үүссэн маргаантай холбогдон гарсан хуулийн зардал өртөг нөхөгдөх зардалд хамаарахгүй)

4.9.1.11.5. Гэрээлэгч эсхүл оператор компанийн салбар компанийн хуульч нь өөрийн компанидаа хууль зүйн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдон гарах зардлыг

хөдөлмөр эрхлэлт, эсхүл салбар компаниудын үйл ажиллагааны зардалд хамааруулан өртөг нөхөгдөх зардалын тооцоонд оруулна.

#### 4.9.1.12. Сургалтын зардал

4.9.1.12.1. Гэрээлэгч эсхүл оператор компани нь захиргааны ажиллагсдаас бусад ажиллагсдыг (өөрийн) гүйцэтгэж байгаа ажил мэргэжлийн чиглэлээр богино хугацааны сургалтанд хамруулах, дадлагажуулахад зарцуулсан зардлуудыг хамруулна.

4.9.1.12.2. Гэрээлэгч эсхүл оператор компанийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн шүүхийн маргаантай холбогдон гарах зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцохгүй.

#### 4.9.1.13. Захиргааны зардал

4.9.1.13.1. Захиргааны зардалд гэрээлэгч эсхүл оператор компанийн Монгол Улс дахь төв оффистой холбоотой захиргааны зардал, гадаад улс дахь ерөнхий удирдлага, хувь нийлүүлэгчийн болон хянах, үйлчлэх, зөвлөх үүрэг бүхий захиргааны ажилтай холбогдон гарах зардлыг бүртгэнэ. Тухайлбал: Ерөнхий ба удирдлагын зардлыг удирдлага болон түүнд туслах, үйлчлэх ажилтануудын цалин, нийгмийн даатгал шимтгэл, албан татвар, төлбөр, хураамж, томилолт, бичиг хэрэг, шуудан холбоо, мэргэжлийн үйлчилгээ, сургалт, сонин сэтгүүл захиалга, даатгал, цахилгаан, ус, дулаан, засвар, элэгдэл хорогдол, түрээс, орон байрны зардал, харуул хамгаалалт, цэвэрлэгээ үйлчилгээ, тээвэр, шатахуун, хүлээн авалт, гадаад улсад гарсан хууль эрх зүйн үйлчилгээний зардлууд багтаана.

4.9.1.13.2. Захиргааны дээрх зардал нь гэрээлэгч эсхүл оператор компанийн тухайн жилийн өртөг нөхөгдөх зардлын 5 хүртэл хувь байна.<sup>2</sup>

4.9.1.13.3. Тухайн жилийн өртөг нөхөгдөх зардал дээр дээрх хувиар тооцсон захиргааны зардлыг нэмж тухайн жилийн нийт өртөг нөхөгдөх зардлыг тооцно.

4.9.1.13.4. Захиргааны зардлыг 4.9.1-4.9.10-т заасан зардлуудад давхардуулан тооцохгүй.

### 4.9.2. Өртөг нөхөгдөхгүй зардал

4.9.2.1. Анхан шатны баримт бүрдүүлээгүй, зөрчилтэй, гүйлгээний нэр данс зөрүүтэй, хангалттай баримтжуулаагүй, бүртгэлгүй зардал;

---

<sup>2</sup> Энэхүү зардалд ноогдох хувийг Газрын тосны тухай хуулийн 3 дугаар бүлэг 11.1.6-д "Гэрээлэгчийн захиргааны зардал нь тухайн жилийн өртөг нөхөх зардлын 5% (хувь) хүртэл хувь байх" заасны дагуу тогтооно.

- 4.9.2.2. Холбогдох ажлын төлөвлөгөө, төсвийн дагуу зарцуулагдаагүй, хэтрүүлсэн эсхүл гэрээнд зөвшөөрөөгүй ангилалд хамаарах зардал;
- 4.9.2.3. Гэрээлэгч эсхүл оператор компанийн худалдан авсан бараа, гүйцэтгүүлсэн болон захиалсан үйлчилгээний үнэ тухайн үеийн адил чанарын бараа, үйлчилгээний ижил нөхцөл дэх бодит үнийн жишгээс илүү гарсан зардал;
- 4.9.2.4. Туслан гүйцэтгэгч болон нийлүүлэгчтэй байгуулсан гэрээнд зааснаас өөр бараа, үйлчилгээний төлбөр;
- 4.9.2.5. Энэхүү журмын 4.7.2.3-т заасны дагуу бараа үйлчилгээ нь үнэтэйгээ таарахгүй нөхцөлд уг зөрчилтэй холбогдон гарсан нэмэгдэл зардал;
- 4.9.2.6. Газрын тосны үйл ажиллагаанд хамаарахгүй зардал;
- 4.9.2.7. Монгол улс болон гадаад улсад төлсөн татвар, хураамж;
- 4.9.2.8. Тусгай зөвшөөрлийн төлбөр болон урамшуулал, үйлчилгээний хөлс бусад төлбөр;
- 4.9.2.9. Гэрээлэгч эсхүл оператор компанийн үйл ажиллагаатай холбоотой гарсан шүүхийн зардал;
- 4.9.2.10. Гэрээлэгч эсхүл оператор компанийн хууль тогтоомж болон БХГ-ээг зөрчсөний улмаас үүссэн зардалд гэрээлэгч, түүний оператор компани болон туслан гүйцэтгэгчийн аливаа хайнга хайхрамжгүй үйлдэл, эс үйлдэл, ухамсартайгаар гаргасан зөрчлийн улмаас гарсан зардал (үүнд хайхрамжгүйгээр эсхүл ухамсартайгаар зөрчил гаргасан эсэхээ хүлээн зөвшөөрч, сайн дурын үндсэн дээр тухайн төлбөрийг төлсөн эсэхээс үл хамааран хайхрамжгүй эсхүл ухамсартайгаар зөрчил гаргасан үндэслэлээр үүссэн аливаа маргааныг шийдвэрлэхэд төлсөн төлбөр орно.);
- 4.9.2.11. Монгол Улсын шүүх болон эрх бүхий бусад байгууллагаас ногдуулсан торгууль, алданги;
- 4.9.2.12. Гэрээний талын ашиг сонирхол, нэр хүндийг дээшлүүлэх, олон нийттэй харилцах харилцааг сайжруулахтай холбогдон гарсан бөгөөд төрийн захиргааны байгууллагаас бичгээр зөвшөөрөгдөөгүй хандив болон бусад зардал;
- 4.9.2.13. Газрын тос хайх, олборлох, ашиглахад зориулсан шинэ тоног төхөөрөмж, материал болон аргачлалыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилгоор судалгаа хийхтэй холбогдон гарсан зардал;
- 4.9.2.14. Зээлийн хүүгийн зардал (эсхүл зээлийн хүүгийн шинж чанар бүхий, зээлийн хүүгийн оронд төлсөн эсхүл зээлийн хүүгийн бизнесийн үйлчлэл бүхий аливаа төлбөр) зээлийн бүтээгдэхүүний тухайд гарсан бусад зардал, банкны

хураамж, валютын ханшийн алдагдал болон ханшийн алдагдлаас урьдчилан сэргийлэх зорилгоор авах арга хэмжээний зардал;

4.9.2.15. Гэрээлэгч гуравдагч этгээдтэй хамтран компани үүсгэн байгуулах эсхүл хамтран ажиллахтай холбоотой гарсан зардал (Үүнд энэхүү гэрээнд заасан хувь оролцооны эрх шилжүүлэхтэй холбогдуулан төлсөн аливаа төлбөр, шимтгэл, худалдан авах зардал, үүний дотор цэвэр ашгийн хувь, эрх худалдах болон түүнтэй адилтгах аливаа төлбөрийг мөн хамруулна);

4.9.2.16. Хувьцаа гаргах болон ногдол ашиг төлөх зардал;

4.9.2.17. Зээлийн хөрөнгийн болон үнэт цаас, хувьцааны буцаан төлөлт;

4.9.2.18. Бүтээгдэхүүн хуваалтаар гэрээлэгчид эсхүл оператор компанид ногдох газрын тосонд ногдуулсан төлбөр болон эдгээртэй төстэй зардал;

4.9.2.19. Гэрээ хэлэлцээ хийх, гарын үсэг зурах, батлуулахтай холбоотой зардал;

4.9.2.20. Гэрээт талбайд ажил гүйцэтгэсэн боловч холбогдох мэдээлэл, тайлан, баримт материалыг төрийн захиргааны байгууллагад хүлээлгэн өгөөгүй ажил, үйлчилгээний зардал эсхүл хүлээлгэн өгсөн боловч шаардлагад нийцэхгүйн улмаас хүлээн аваагүй ажил, үйлчилгээний зардал;

4.9.2.21. БХГ-нд заасан санхүүгийн хяналт шалгалт, баталгаажуулалт болон нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой зардал, хураамж, компанийн дотоод хяналт шалгалт, санхүүгийн тайлан тооцоо, бүртгэлтэй холбогдон гарсан зардал;

4.9.2.22. Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, газрын тосны хөрөнгийн элэгдэл, хорогдлын шимтгэл;

4.9.2.23. Захиргааны зориулалтаар худалдан авсан биет болон биет бус хөрөнгө

4.9.2.24. Гэрээлэгч эсхүл оператор компанийн хариуцлагагүй байдлын улмаас устсан, алдагдсан эсхүл төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлгүй худалдсан, шилжүүлсэн эд хөрөнгийн зардал;

4.9.2.25. Гэрээлэгч эсхүл оператор өөрийн буруугаас байгаль орчныг бохирдуулсныг нөхөн сэргээх зардал;

4.9.2.26. Гэрээлэгч эсхүл оператор компанийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн шүүхийн маргаантай холбогдон гарах зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцохгүй.



4.9.2.27. 4.9.1-д тусгагдаагүй бусад зардлыг өртөг нөхөгдөхгүй зардалд хамааруулна.

### **ТАВДУГААР БҮЛЭГ. ӨРТӨГ НӨХӨГДӨХ ЗАРДАЛД ТООЦОГДОХ ҮНДСЭН ХӨРӨНГӨ, БАРАА МАТЕРИАЛ**

5.1. Гэрээлэгч эсхүл оператор компани нь үндсэн хөрөнгө, бараа материалыг худалдан авах, үнэлэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах тэдгээртэй холбогдон гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх, тооллого хийж, гүйцэтгэлийг тооцож, тэдгээрийг тайлагнах зэрэг үйл ажиллагааг хамруулна.

5.2. Үндсэн хөрөнгө, бараа материалыг худалдан авах

5.2.1. Гэрээлэгч эсхүл оператор компани нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авалтын журмыг боловсруулан, Газрын тосны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагаар хянуулан, дагаж мөрдөнө.

5.2.2. Гэрээлэгч эсхүл оператор компани нь 5.2.1-т заасан худалдан авалтын журамд үндсэн хөрөнгө, бараа материал, ажил, үйлчилгээний гэсэн ангилал тус бүрээр харьцуулалт, шууд худалдан авалт болон зөвлөх сонгох төсөвт өртгийн дээд хязгаарыг тогтоосон босго үнийг тусгаж өгнө.

5.2.3. Гэрээлэгч эсхүл оператор компани нь үндсэн хөрөнгө, бараа материалыг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан төсөв болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр баталсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу худалдан авна.

5.2.4. Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

5.2.5. Үндсэн хөрөнгө, бараа материалын үнийг гэрээлэгч эсхүл оператор компанид үзүүлсэн бүх хөнгөлөлтийг нь хасаад түүний бодит төлсөн үнийн дүнг дараах үнэлгээний зарчмын дагуу бараа материалыг эхэлж авсанаа эхэлж зарлагадах үед, үндсэн хөрөнгийг худалдан авах үед өртөг нөхөгдөх зардалд тооцно.

5.3. Худалдан авсан болон худалдсан үндсэн хөрөнгө, бараа материалыг үнэлэх

5.3.1. Худалдан авсан эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийн үнэ нь адил чанарын барааны олон улсын зах зээлийн үнэ, худалдан авах хэлэлцээр байгуулах үед олон улсын зах зээлд давамгайлж байсан нийлүүлэлтийн адил нөхцлийн үнийн жишигтэй нийцсэн байна.

5.3.2. Харилцан хамаарал бүхий байгууллагаас худалдан авсан болон тэдэнд худалдсан шинэ эд материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгсэл нь гэрээлэгч эсхүл оператор компанийн гэрээ байгуулах үеийн адил чанарын барааны олон улсын зах зээлийн үнэ, нийлүүлэлтийн адил нөхцлийн жишиг үнэтэй нийцэж байна.

5.3.3. Үйлдвэрлэл үйлчилгээнд ашиглаж байсан, эвдрэл гэмтэлгүй, засвар үйлчилгээ шаардагдахгүй, ашиглах боломжтой материал, тоног төхөөрөмж болон сэлбэг хэрэгслийг худалдаж авсан өртгөөр нь өртөг нөхөгдөх зардалд тооцно.

5.3.4. Гэрээлэгч эсхүл оператор компани нь худалдан авсан үндсэн хөрөнгө, бараа материал гэмтэл согогтой байвал "үйлдвэрлэгч буюу худалдагч" нь гэрээлэгч эсхүл оператор компанид зөрүүг нөхөн төлөх хүртэл худалдан авсан бараа материал, тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг өртөг нөхөгдөх зардалд тооцохгүй.

#### 5.4. Засгийн газрын өмчлөлд шилжүүлэх

5.4.1. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны хугацаа дуусах үед Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд зориулан Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулж ирсэн гэрээлэгч эсхүл оператор компанийн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материал, үл хөдлөх хөрөнгийг гэрээний хугацаа дуусгавар болохоос өмнө эсхүл дуусгавар болсны дараа өмчлөх асуудлыг талууд харилцан тохиролцож, шийдвэрлэнэ.

5.4.2. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагаанд зориулан Монгол Улсын нутаг дэвсгэрт оруулж ирсэн гэрээлэгч эсхүл оператор компанийн өртөг нөхөгдөх зардалд тооцогдсон техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бараа материал, түүхий эд материал, үл хөдлөх хөрөнгийг гэрээний хугацаа дууссаны дараа Засгийн газар тухайн талбайд хайгуул ашиглалтын үйл ажиллагааг үргэлжлүүлэх шаардлагатай бол нэмэгдэл төлбөргүйгээр Монгол Улсын өмч болно.

5.4.3. Үндсэн хөрөнгө, бараа материал шилжүүлэхтэй холбогдон гарах зардлыг гэрээлэгч эсхүл оператор компани хариуцна.

5.4.4. Гэрээлэгч эсхүл оператор компанийн түрээсээр авч ашиглаж байгаа техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, бусад эд хөрөнгө хамаарахгүй.

#### 5.5. Үндсэн хөрөнгө, бараа материалыг худалдах

5.5.1. Өртөг нөхөгдөх зардалд тооцогдсон үндсэн хөрөнгө, бараа материалыг худалдан борлуулахдаа Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас зөвшөөрөл авна.

5.5.2. Үндсэн хөрөнгийг борлуулах бол тухайн хөрөнгийн үлдэгдэл өртгөөр (дансны үнээс хуримтлагдсан элэгдлийг хассан дүн) өртөг нөхөгдөх зардлыг бууруулна.

5.6. Үндсэн хөрөнгө, бараа материалыг акталж, данснаас хасах

5.6.1. Гэрээлэгч эсхүл оператор компани нь хагас болон бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогын дүн, гэрээлэгч эсхүл оператор компанийн тооллогын комиссын дүгнэлт, санал, удирдлагын шийдвэрийг үндэслэн хөрөнгө акталж данснаас хасах тухай асуудлаа газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлж, газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцсөний дагуу газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалын шийдвэр гарсны дараа хэрэгжүүлнэ.

5.6.2. Гэрээлэгч эсхүл оператор компани нь эд хөрөнгө актлах саналаа газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрх бүхий байгууллагад ирүүлэхдээ дор дурдсан зүйлийг заавал тусган хүснэгтээр илэрхийлсэн байна:

5.6.2.1. Данснаас хасах эд хөрөнгө, бараа материалын тодорхойлолт, хүсэлт;

5.6.2.2. Тоо хэмжээ;

5.6.2.3. Данснаас хасах болсон шалтгаан;

5.6.2.4. Уг эд хөрөнгө, бараа материалыг акталж устгах, тухай санал, хүсэлт;

5.6.2.5. Гэрээлэгч эсхүл оператор компанийн тооллогын комиссын дүгнэлт, удирдлагын хурлын тэмдэглэл, шийдвэр,

5.6.2.6. Байгалийн гэнэтийн аюул, техникийн осол, гэмтэлд өртсөн эд хөрөнгийн шалтгааны тухай мэргэжилийн байгууллагын акт дүгнэлт

5.6.3. Гэрээлэгч эсхүл оператор компанийн өртөг нөхөгдөх зардалд тооцсон хөрөнгө, бараа материалыг дараах тохиолдолд данснаас хасна. Үүнд:

5.6.3.1. Элэгдлийн нийт хэмжээ, ашиглалтын хугацаагаараа балансын үнээ нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон,

5.6.3.2. Ашиглалтын хугацаа нь дуусаагүй боловч ашиглах явцад эвдэрч гэмтэн, цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон,

5.6.3.3. Техник, технологийн болон хэрэглээний хоцрогдолд орж, зайлшгүй шинэчлэх шаардлагатай болсон эд хөрөнгө,

5.6.3.4. Балансын үнээ бүрэн нөхөөгүй боловч байгалийн гэнэтийн аюул, техникийн осолд өртсөнөөс цаашид зориулалтын дагуу ашиглах боломжгүй болсон,

5.6.3.5. Ашиглалтын явцад эвдэрч гэмтсэнээс засвар шинэтгэл хийж ашиглахад эдийн засгийн хувьд үр ашиггүй болох нь тооцоогоор нотлогдсон,

5.6.3.6. Төрийн захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд тухайн эд хөрөнгийн иж бүрдэл, чанар байдал, бүрэн бүтэн байлгах асуудлыг компанийн удирдлага хариуцаж, харуул хамгаалалттай байлгах үүрэг хүлээх бөгөөд эд хөрөнгийн бүрэн бүтэн байдал алдагдвал хариуцлагыг хууль тогтоомжийн хүрээнд гэрээлэгч эсхүл оператор компанийн удирдлага хүлээнэ.

5.7. Үндсэн хөрөнгө, бараа материалын тооллого

5.7.1. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Гэрээлэгч эсхүл оператор компани харилцан тохиролцож, тогтоосон хугацаанд (жил бүрийн эхний улиралд) гэрээлэгч эсхүл оператор компанийн үйл ажиллагааны бүх эд материал, биет хөрөнгө, барилга байгууламжийн тооллогыг тооллогын удирдамжийн дагуу явуулна.

5.7.2. Тооллогын удирдамжийг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга батална.

5.7.3. Тооллогын комисс нь гэрээлэгч эсхүл оператор компанийн холбогдох мэргэжилтнүүд болон санхүүгийн ажилтнууд, төрийн захиргааны байгууллагын төлөөллөөс бүрдэх бөгөөд шаардлагатай тохиолдолд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төлөөлөл оролцоно.

5.7.4. Тооллогын комиссын бүрэлдэхүүнд орсон хүмүүсийг тооллого явуулж, тооцоо бодон үр дүнг гаргаж дуусгах хүртэл хугацаанд үүрэгт ажлаас нь чөлөөлж, онцлох шалтгаангүйгээр өөр ажилд дайчлахыг хориглоно.

5.7.5. Эд хөрөнгийн тооллогыг тухайн эд хөрөнгийг гардан хариуцаж байгаа эд хариуцагч нарыг заавал байлцуулан явуулна.

5.7.6. Гэрээлэгч эсхүл оператор компанийн удирдлага тооллогыг үнэн зөв, цаг хугацаанд нь явуулахыг хариуцах ба тооллогын комиссыг ажиллах нөхцөл бололцоогоор бүрэн хангана.

5.7.7. Агуулахад байгаа бараа материал, хангамжийн зүйлс, сэлбэг хэрэгслийг төрөлжүүлэн код дугаартай болгон цэгцэлсэн байна.

5.7.8. Бараа материалын орлого зарлагыг цэгцлэн шалгаж нэр, төрлийн бүртгэлийг хөтлүүлж, тайлан гаргуулан, үлдэгдлийг шалгаж баталгаажуулна.

5.7.9. Ажилтанд тавьж олгосон эд хөрөнгийн жагсаалтыг картаар хөтлүүлж, хариуцагчийн гарын үсгээр баталгаажуулсан байна.

5.7.10. Өмнө явагдсан тооллогын үр дүнг данснаас хасагдах үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийг борлуулах, акталж устгах зэргээр холбогдох шийдвэрийг хавсарган бүрэн шийдвэрлүүлж, үр дүнг данс бүртгэлд тусгасан байна.

5.7.11. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу эрх шилжүүлэх тохиолдолд гэрээлэгч эсхүл оператор компани нь эрх шилжүүлэн авагчийн хүсэлтээр эд хөрөнгийн тусгай тооллогыг хийж болох бөгөөд холбогдох зардлыг гэрээлэгч эсхүл оператор бүрэн хариуцна.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ. ГАЗРЫН ТОСНЫ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР,  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨЛБӨР БОЛОН УРАМШУУЛАЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХӨЛС, БУСАД ТӨЛБӨРИЙГ ТӨЛӨХ, ХУВААРИЛАХ, ЗАРЦУУЛАХ**

6.1. Газрын тосны нөөц ашигласны төлбөр болон хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулахдаа Засгийн газрын 2018 оны 1 дүгээр сарын 3-ны 5 дугаар тогтоолоор баталсан “Нөөц ашигласны төлбөр болон тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, хуваарилах, зарцуулах” журмыг мөрдөнө.

6.2. Урамшуулал, үйлчилгээний хөлс, бусад төлбөр

6.2.1. Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан хувь хэмжээгээр дараах урамшууллыг тооцож, газрын тосны тухай хуулиар тогтоосон хугацаанд харъяалах байгууллагуудад төвлөрүүлэн шилжүүлнэ.

Д/д	Урамшууллын нэр төрөл	Хоног хугацаа	Төвлөрүүлэн шилжүүлэх
1	Гэрээнд гарын үсэг зурсны урамшуулал (гэрээт жил эхэлснээс хойш)	60 хоног дотор	Улсын төсөвт
2	Олборлолт эхэлсний урамшуулал (олборлолт эхэлсэн өдрөөс хойш)	30 хоног дотор	Улсын төсөвт
3	Олборлолт нэмэгдүүлсний урамшуулал (БХГ-нд заасан хувь хэмжээгээр)	хуанлийн сарын дараагийн сард багтаан	Улсын төсөвт
4	Сургалтын урамшуулал (БХГ-нд заасан хувь хэмжээгээр)	жил бүр	Газрын тосны асуудал эрхэлсэн Төрийн
4.1	гэрээт жил эхэлснээс хойш	60 хоног дотор	
4.2	санхүүгийн жил эхэлснээс хойш	30 хоног дотор	

Д/д	Урамшууллын нэр төрөл	Хоног хугацаа	Төвлөрүүлэн шилжүүлэх
			захиргааны байгууллагад
5	Төлөөлөгчийн газрын үйл ажиллагааны дэмжлэг (БХГ-нд заасан хувь хэмжээгээр)		Газрын тосны асуудал эрхэлсэн
5.1	гэрээт жил эхэлснээс хойш	60 хоног дотор	Төрийн захиргааны байгууллагад
5.2	санхүүгийн жил эхэлснээс хойш	30 хоног дотор	
5.3	Төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг дэмжихэд зориулж	жил бүр	
6	Орон нутгийг хөгжүүлэх урамшуулал (БХГ-нд заасан хувь хэмжээгээр)	жил бүр	Орон нутгийг хөгжүүлэх санд
6.1	гэрээт жил эхэлснээс хойш	60 хоног дотор	
6.2	санхүүгийн жил эхэлснээс хойш	30 хоног дотор	
7	Засгийн газарт санал болгох бусад ашигтай нөхцөл	БХГ-гээр зохицуулагдана	
8	Үйлчилгээний хөлс		
8.1	Хайгуулын талбайн захиалгын,	20 мянган ам.доллартай тэнцэх мөнгөн дүн	Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад
8.2	Хайгуулын талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд	100 мянган ам.доллартай тэнцэх мөнгөн дүн	Улсын төсөвт
8.3	Ашиглалтын талбайн хэмжээг нэмэгдүүлэхэд	250 мянган ам.доллартай тэнцэх мөнгөн дүн	
8.4	Гэрээний эрх үүргээ шилжүүлэхдээ хайгуулын талбайд нээлт тогтоогдохоос өмнө,	20 мянган ам.доллартай тэнцэх мөнгөн дүн	
8.5	Хайгуулын тайлбайд нээлт тогтоогдсоны дараа,	50 мянган ам.доллартай тэнцэх мөнгөн дүн	Улсын төсөвт

Д/д	Урамшууллын нэр төрөл	Хоног хугацаа	Төвлөрүүлэн шилжүүлэх
8.6	Ашиглалтын үед гэрээний эрх үүргээ шилжүүлбэл	100 мянган ам.доллартай тэнцэх мөнгөн дүн	

## ДОЛООДУГААР БҮЛЭГ. АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ

7.1. Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрэл, хайгуул, ашиглалтын, татан буулгалтын ажлын жилийн төлөвлөгөө, төсвийг Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталж, гүйцэтгэлд хяналт тавина.

7.2. Шаардлагатай тохиолдолд Төрийн захиргааны байгууллагын зөвшөөрснөөр жилийн төлөвлөгөө, төсөвт хуанлийн жилийн 9 дүгээр сарын 30-наас өмнө нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь нэмэлт, өөрчлөлт оруулах төлөвлөгөө, төсвийг ирүүлсэн өдрөөс хойш ажлын 15 (арван тав) хоногийн дотор батална.

7.3. Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан өдрөөс хойш ажлын төлөвлөгөө, төсвийн хугацааг хуанлийн жилээр тооцно.

7.4. Гэрээлэгч эсхүл оператор компани нь тухайн жилийн батлагдсан төлөвлөгөө, төсөвт тусгагдаагүй зөвлөх, гэрээт үйлчилгээ болон хангамжаар үйлчлүүлэхтэй холбогдсон зардал гарахаар бол зөвшөөрлийг төрийн захиргааны байгууллагаас урьдчилан бичгээр авах бөгөөд уг зардал нь ижил төстэй ажил, үйлчилгээ үзүүлэх гадаадын болон Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагад төлөх зардалтай ойролцоо байна.

7.5. Газрын тосны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллага нь эхний жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулсан өдрөөс хойш 120 хоногийн дотор, дараагийн жилээс хайгуулын ажлын төлөвлөгөө, төсвийг тухайн жилийн эхний улиралд багтаан батална.

7.6. Тухайн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөө нь Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуух хайгуулын ажлын доод хэмжээнээс багагүй байна.

7.7. Гэрээлэгч эсхүл оператор компани нь ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон өдрөөс хойш 60 хоногийн дотор ашиглалтын эхний жилийн төлөвлөгөө, төсвийг Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар батлуулна.

7.8. Гэрээлэгч эсхүл оператор компани нь ашиглалтын хоёр дахь жилээс эхлэн тухайн жилийн ашиглалтын төлөвлөгөө, төсвийн төслийг хуанлийн өмнөх жил

дуусахаас 90 хоногийн өмнө Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

7.9. Тухайн жилийн ашиглалтын төлөвлөгөө, төсөв нь орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөөтэй нийцсэн байна.

7.10. Гэрээлэгч эсхүл оператор компанийн гэрээний хугацаа дуусгавар болох үед хэрэгжүүлэх татан буулгалтын төлөвлөгөө нь “Орд ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний нэг бүрэлдэхүүн хэсэг болох бөгөөд татан буулгалтын төлөвлөгөөнд байгаль орчныг бүрэн гүйцэд нөхөн сэргээх болон хайгуул, ашиглалтын үед ашигласан тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, барьсан барилга байгууламжийг татан буулгах, нүүлгэн шилжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааны дэс дараалал, ажлын төрөл, хэмжээ, хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зэрэг асуудлыг тусгана.

## НАЙМДУГААР БҮЛЭГ. ЖИШИГ ҮНЭ, СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮНЭ

8.1. Бодит үнийг “Сунгасан гарын зарчим”-аар тогтооно. Харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдэж буй үйлдвэрлэл, худалдаа, санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэсэн үнэ нь харилцан хамааралгүй этгээдүүдийн хоорондох ажил гүйлгээний үнээс ялгаатай байвал харьцуулагдах байдлын шинжилгээ хийх болон тооцооллын аргуудыг ашиглан бодит үнийг тодорхойлж болно.

8.2. Харилцан хамаарал бүхий этгээдүүдийн хооронд хийгдсэн ажил гүйлгээний жишиг үнэ, сонгон шалгаруулалтын үнийг баримтлахдаа Сангийн сайдын 2015 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 353 тоот тушаалын 1 дүгээр хавсралтыг даган мөрдөнө.

8.3. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хайгуул, ашиглалтын гэрээт ажил, үйлчилгээнд баримтлах жишиг үнийг тогтоож болно. Гэрээлэгчийн гэрээт ажил, үйлчилгээний үнэ нь уг тогтоосон жишиг үнээс хэтрэхгүй байна. Жишиг үнээс хэтрэх нөхцөл байдал үүсэх тохиолдолд Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.

## ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН БҮРТГЭЛ, ТООЦОО

### 9.1. СТОУС-ын дагуу

9.1.1. Гэрээлэгч эсхүл оператор компани нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ гадаад валютаарх ажил гүйлгээ, үлдэгдлийн бүртгэлийг НББОУС 21 *Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө* стандартын дагуу; бүртгэлийн валютыг тогтоох, тайлагналын валютад хөрвүүлэхдээ Сангийн сайдын 2017 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 249 тоот тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн валютыг тогтоох, өөрчлөх, санхүүгийн тайланг хөрвүүлэх” журмыг мөрдөнө.



## 9.2. БХГ-ний дагуу

9.2.1. Гэрээлэгч эсхүл оператор компани нь хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдөх болон нөхөгдсөн зардал, орлогын бүртгэлийг америк доллараар хөтөлж, тайлагнана.

9.2.2. Монгол Улсын мөнгөн тэмдэгтээр болон бусад валютаар хийгдсэн орлого, зардлыг гүйлгээ гарсан тухайн өдрийн Монголбанкны албан ханшаар ам.долларт шилжүүлж, бүртгэнэ.

### АРАВДУГААР БҮЛЭГ. ЭСКРОУ ДАНСЫГ БАЙРШУУЛАХ, ЗАРЦУУЛАХ

#### 10.1. Эскроу дансанд мөнгөн хөрөнгө байршуулах

10.1.1. Гэрээлэгч нь байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, хайгуул, ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгаа болох мөнгөн хөрөнгийг Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг банкны эскроу дансанд байршуулна.

10.1.2. Уг журмын 10.1.1-д заасан мөнгөн хөрөнгийг байршуулахдаа Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг банкыг гэрээлэгч сонгох бөгөөд эскроу данс эзэмших гэрээг банк, гэрээлэгч болон газрын тосны асуудал эрхэлсэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэсэн 3 тал хамтарч гэрээг байгуулна.

#### 10.2. Эскроу дансанд байршуулах баталгаа хөрөнгийг тооцохдоо:

10.2.1. Хайгуулын үед тухайн жилд хайгуулын талбайд хийх ажлын төлөвлөгөөнд батлагдсан ажлын үнийн дүнгийн гурван хувь (3%)-тай тэнцэх мөнгийг:

10.2.2. Хайгуулын үед байршуулсан мөнгөн хөрөнгийн тавин хувь (70%)-ийг байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэхэд,

10.2.3. Хайгуулын үед барилга, байгууламжийг татан буулгахад тавин хувь (30%)-ийг тус тус баталгаа болгоно.

10.2.4. Ашиглалтын үед тухайн жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан олборлох түүхий тосны хэмжээг үндэслэн төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас улсын төсвийн төсөл баталахад мөрдсөн түүхий тосны үнийн жишиг, гэрээлэгчтэй байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээ болон бусад эрх зүйн баримт бичигт тусгагдсаны дагуу хуваах түүхий тосны тооцоог хийж, гэрээлэгчид ногдох тосны нэг хувь (1%)-тай тэнцэх мөнгийг дараах үйл ажиллагаанд зориулж, төлөвлөгөө баталагдсанаас хойш 60 хоногийн дотор банкинд байршуулна.

10.2.5. Ашиглалтын үед байршуулсан мөнгөн хөрөнгийн тавин хувь (50%)-ийг байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэхэд,

10.2.6. Ашиглалтын барилга, байгууламжийг татан буулгахад тавин хувь (50%)-ийг тус тус баталгаа болгоно.

10.2.7. Ашиглалтын барилга байгууламжийг татан буулгах баталгааг ашиглалтын хугацаа дуусах хүртэл жил бүр хуримтлуулан байршуулах бөгөөд нийт баталгааны дүн нь нийт хөрөнгө оруулалтын арван хувь (10%)-иас хэтрэхгүй байна.

10.2.8. Баталгаа хөрөнгийг журмын 10.1.3-д заасан хугацаанд байршуулаагүй тохиолдолд хоног тутамд 0.01 хувийн алданги төлнө.

10.2.9. Гэрээлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй бол газрын тосны асуудал эрхэлсэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага баталгаа хөрөнгөөр нөхөн сэргээлт хийлгэх ажлыг холбогдох хууль, журмын хүрээнд хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар хийлгэх ажлыг зохион байгуулж болох бөгөөд баталгаа хөрөнгө хүрэхгүй тохиолдолд нэмж шаардагдах хөрөнгийг гэрээлэгчээс нөхөн гаргуулна.

10.2.10. Баталгаа хөрөнгийг төгрөгөөр тооцож төлөвлөх, дансанд байршуулах бол тухайн өдрийн Монгол банкны валютын албан ханшаар тооцно.

10.2.11. Банкны үйлчилгээний хүү, шимтгэлийг гэрээлэгч хариуцна.

10.3. Эскроу дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг чөлөөлөх

10.3.1. Гэрээлэгч холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлсэн тохиолдолд эскроу дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг чөлөөлөх зөвшөөрлийг газрын тосны асуудал эрхэлсэн газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага олгоно.

10.3.2. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас гэрээлэгчийн жилийн ажлын гүйцэтгэл, үр дүнг дараа жилийн 3 дугаар сарын 1-ний дотор тооцож байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлэх, эскроу дансанд байршуулсан баталгаа хөрөнгийг чөлөөлөх эсэх талаар дүгнэлт гаргана.

10.3.3. Дараагийн жилийн ажлын төлөвлөгөө батлагдаж, баталгаа хөрөнгийг тооцож төлөх хүртэл өмнөх жилийн баталгааг байршуулах бөгөөд дараагийн баталгааны тооцоогоор гарсан зөрүүг чөлөөлөх, эсвэл нэмж байршуулна.

10.3.4. Банк нь газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захигааны байгууллагын дүгнэлт, зөвшөөрөлгүйгээр гэрээлэгчийн байршуулсан хөрөнгийг чөлөөлсөн, өөр зориулалтаар зарцуулсан бол хариуцлага тооцуулахаар монгол банкинд хандана.

10.4. Эскроу дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг зарцуулах

10.4.1. Гэрээлэгч холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ бүрэн гүйцэд биелүүлээгүй тохиолдолд эскроу дансанд байршуулсан мөнгөн хөрөнгийг Засгийн газар уг эскроу дансанд байршуулсан мөнгөн хөрөнгөөр гүйцэтгүүлнэ.

10.5. Эскроу дансан дахь мөнгөн хөрөнгийг бүртгэх

10.5.1. Газрын тосны компани эскроу дансанд энэхүү журмын ....-д заасан мөнгөн хөрөнгийг байршуулахдаа дараах нягтлан бодох бүртгэлийн бичилтийг хийнэ.

Дт	Хязгаарласан мөнгөн хөрөнгө
Кт	Мөнгөн хөрөнгө

#### АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ХАЙГУУЛ, АШИГЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТҮР ЗОГСООХ

11.1. Гэрээлэгч нь техникийн осол, саатал гарсан, шүүхийн шийдвэр болон эрх бүхий этгээдийн актаар үйл ажиллагааг зогсоосон, давагдашгүй хүчин зүйл болон бусад шалтгаанаар хайгуул, бүтээн байгуулалт, ашиглалт, борлуулалтын үйл ажиллагаа зогссон эсхүл Монгол улсад эдийн засгийн хямрал үүсэх, төсөл үр ашиггүй болох, дэлхийн зах зээл дээр газрын тосны үнэ унах зэргээр санхүүгийн хүндрэлд орох, гэрээлэгчийн үйл ажиллагаатай холбогдуулан орон нутгийн эсэргүүцэл бий болох зэрэг тохиолдолд Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

11.2. “Давагдашгүй хүчин зүйл” гэж гал түймэр, гоц халдварт өвчний тархалт, гарцаагүй осол, зарласан буюу зарлаагүй дайн, үймээн, самуун, үер, хүчтэй шуурга, газар хөдлөлт болон байгалийн бусад гамшигт үзэгдлийг ойлгоно.

11.3. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас БХГ-ний нөхцлийг биелүүлээгүй тохиолдолд гэрээг зөрчсөнд тооцохгүй.

11.4. Гэрээлэгч нь уг журмын 11.2-д заасан давагдашгүй хүчин зүйл тохиолдсон өдрөөс эхлэн 30 (гуч) хоногийн дотор энэ тухай төрийн захиргааны байгууллагад эрх бүхий (мэргэжлийн хяналт, онцгой байдал, эрүүл ахуй гэх мэт байгууллагууд) байгууллагаар нотлуулсан акт, нотолгооны хамт гаргаж өгнө.

11.5. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гэрээлэгч эсвэл оператор компанийн хүсэлтээр газрын тосны хайгуул, ашиглалтын хугацааг түр зогсоож болно.

11.6. Үйл ажиллагааг зогсоосон хугацаагаар хайгуулын болон ашиглалтын хугацааг сунгаж тооцно. 1 жил хүртэлх хугацаагаар сунгах бол Газрын тосны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллага, 1 жилээс дээш хугацаагаар сунгах бол Газрын тосны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

11.7. Гэрээлэгч түр зогссон үед БХГ-нд заасан төлбөр, урамшууллыг төлөхгүй, тус хугацаанд гарсан зардлыг өртөг нөхөгдөх зардалд тооцохгүй.

11.8. Гэрээлэгчийн үйл ажиллагаатай холбогдуулан орон нутгийн засаг захиргааны байгууллага эсвэл орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн шийдвэртэй үед орон нутгийн эсэргүүцэл гэж үзнэ.

11.9. Орон нутгийн малчдын өвөлжөө, хаваржааг нүүлгэн шилжүүлэх, бэлчээрийн газрыг хуулийн дагуу өмнөх төлөв байдалд оруулаагүй.

#### АРВАН ХОЁРДУГААР. БҮТЭЭГДЭХҮҮН ХУВААХ ГЭРЭЭНИЙ ДАГУУ ХУВААХ НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР, ӨРТӨГТ ГАЗРЫН ТОС, АШИГТ ГАЗРЫН ТОСНЫ ХУВААРИЛАЛТЫН ТООЦОО, ТОМЬЁО

##### 12.1. Хэмжилт

12.1.1. Бүтээгдэхүүн хуваах гэрээт талбайгаас олборлолт явуулж эхлэхийн өмнө гэрээт талбайн дотоод үйл ажиллагаанд ашиглах, хуримтлуулах, борлуулах газрын тосны хэмжилт хийхэд БХГ-ний талууд дараах зүйлсийг энэхүү журмын ..... заалтуудтай нийцүүлэн харилцан тохиролцоно. Үүнд:

12.1.1.1. Олборлосон газрын тосыг БХГ-ний дагуу хуваах хэмжилтийг хийх цэг буюу хүргэлтийн цэг;

12.1.1.2. Газрын тосны тоо хэмжээ, чанарыг тодорхойлох арга аргачлал;

12.1.1.3. Хэмжилтийн багаж хэрэгсэл, түүнтэй холбогдсон үйл ажиллагааны хяналт, шалгалт;

12.1.1.4. Хэмжилтийн залруулга.

##### 12.2. Хэмжилт хийх цэг

12.2.1. Хэмжилтийн цэг дээр хөндлөнгийн хараат бус мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэнэ.

12.2.2. Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналтын цэгийг тогтоож болно.

12.2.3. Олборлосон газрын тосны хэмжилтийн цэгийн байршлыг Засгийн газрын төлөөлөгч, гэрээлэгч харилцан тохиролцож тогтооно. Хэмжилтийн цэгийн байршлын талаар талууд 30 хоногийн дотор тохиролцож чадаагүй бол Засгийн газрын төлөөлөгчийн нэрлэсэн газарт хэмжилтийн цэгийг тогтооно.

12.2.4. Олборлолтын туршилт болон олборлолтын явцад олборлосон газрын тосыг хэмжилт болон хяналтын цэг дээр эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан хэмжих төхөөрөмжөөр хэмжинэ.

12.2.5. Хэмжилтийн цэг дээр газрын тосыг хэмжих төхөөрөмжийг сонгохдоо Монгол орны цаг уурын байдал, тосны шинж чанар бусад холбогдох хүчин зүйлсийг үндэслэн Засгийн газрын төлөөлөгч, гэрээлэгч харилцан тохиролцоно.

12.3. Хэмжилтийн багаж хэрэгсэл, түүнтэй холбогдсон үйл ажиллагааны хяналт, шалгалт

12.3.1. Гэрээлэгч нь гэрээт талбайгаас олборлосон, дотоод үйл ажиллагаанд ашиглах, хуримтлуулах болон талбайгаас борлуулах газрын тосны аливаа хэмжилтийг хийхдээ олон улсын газрын тосны салбарт хэвшсэн нийтлэг аргачлал болон стандартад нийцсэн хэмжилтийн багаж, хэрэгслийг Засгийн газрын төлөөлөгчтэй хэлэлцэн тохиролцож сонгон ашиглана.

12.3.2. Гэрээлэгч хэмжилтийн үйл ажиллагаандаа өөрчлөлт оруулах нөхцөлд Засгийн газрын төлөөлөгчид урьдчилан мэдэгдэж, харилцан тохиролцоно.

12.3.3. Хэрэв Гэрээлэгч нь хэмжилтийн аль нэг багаж хэрэгсэлд тохируулга хийх, засварлах эсвэл солихыг хүсвэл Засгийн газрын төлөөлөгч, эрх бүхий байгуулагад урьдчилан мэдэгдэж хянуулна.

12.3.4. Хэмжих төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, байнгын хэвийн үйл ажиллагааг хангах, хяналт тавих зорилгоор мэргэшсэн, хөндлөнгийн байгууллагыг ажиллуулна. Үүнтэй холбогдон гарах зардал, төлбөрийг гэрээлэгч бүрэн хариуцна.

12.3.5. Монгол Улсын Засгийн газрын төлөөлөгч нь бүтээгдэхүүн хуваах аливаа хэмжилтийг ямар ч үед ажиглах, үнэн зөвийг тодорхойлох зорилгоор шалгалт хийх эрхтэй. Хэрэв шалгалтаар хэмжилт нь олон улсын газрын тосны салбарт хэвшсэн нийтлэг аргачлал болон стандартад нийцэхгүй болох нь илэрвэл Засгийн газрын төлөөлөгч түүнийг залруулах арга хэмжээ авахыг Гэрээлэгчээс шаардана. Хэрэв Гэрээлэгч нь энэ шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор залруулах арга хэмжээ авч эхлээгүй, эхэлсэн ч явц нь удаашралтай байвал Засгийн газрын төлөөлөгч олборлолтыг зогсоож, эрх

бүхий хөндлөнгийн гүйцэтгэгчээр хэмжилтийг хийлгэж зардлыг Гэрээлэгчээр төлүүлнэ.

12.3.6. Гэрээлэгч нь хэмжилтийн үйл ажиллагаа, хэмжих хэрэгслийг баталгаажуулсан болон түүнд хяналт, шалгалт хийсэн бүх баримтуудыг доод тал нь 10 жилийн хугацаатай аюулгүй, найдвартай газарт хадгалах ба Засгийн газрын төлөөлөгч болон холбогдох төрийн байгууллагууд эдгээр баримтуудтай танилцах эрхтэй. Үүнд дараах баримтууд хамаарна.

12.3.6.1. Гэрээт талбайгаас борлуулах зорилгоор тээвэрлэх тосны ачилт, буулгалт, тээвэрлэлтийн мэдээ

12.3.6.2. Хэмжих хэрэгслийн хянан баталгаажуулалт, хэмжилтийн үр дүн

12.3.6.3. Хэмжих хэрэгсэлд хийсэн калибровка-шалган тохируулга хийсэн тайлан баталгаажуулалт

12.3.6.4. Хэмжих хэрэгсэл худалдан авсан баримт бичиг, түүний техникийн баримт бичиг

12.3.6.5. Осол, гэмтэл гарсан тайлан, түүнийг засварласан баримт мэдээ

12.4. Дээж авалт, лабораторийн шинжилгээ

12.4.1. Газрын тосны дээжийг дараахь стандартын дагуу авч, шинжилгээ хийнэ. Үүнд:

12.4.1.1. Дээж авах

12.4.1.2. ASTM D 4057- Газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүнээс гар аргаар дээж авах тухай стандарт

12.4.1.3. ASTM D 4177- Газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүнээс автомат аргаар дээж авах тухай стандарт

12.4.1.4. ASTM D 5854- Газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний шингэн дээжийг холих, handling-ажиллах тухай стандарт болон бусад холбогдох стандартууд

12.5. Нягт тодорхойлох

12.5.1. ASTM D 1298- Газрын тос болон газрын тосны бүтээгдэхүүний нягт, харьцангуй нягт, API нягтыг гидрометрийн аргаар тодорхойлох тухай стандарт

12.5.2. ASTM D 1657- Хөнгөн нүүрсустөрөгчдийн нягт, харьцангуй нягтыг даралтын гидрометрээр тодорхойлох тухай стандарт

12.5.3. ASTM D 6822-Түүхий тос болон газрын тосны шингэн бүтээгдэхүүний нягт, харьцангуй нягт, API нягтыг термогидрометрийн аргаар тодорхойлох тухай стандарт болон бусад холбогдох стандартууд

12.6. Ус болон механик хольц тодорхойлох:

12.6.1. ASTM D 473-Түүхий тос болон түлшний тосон дахь механик хольцыг уусгах аргаар тодорхойлох тухай стандарт

12.6.2. ASTM D 4006- Түүхий тосон дахь усны агуулгыг нэрлэгийн аргаар тодорхойлох тухай стандарт

12.6.3. ASTM D 4007- Лабораторийн нөхцөлд түүхий тосон дахь ус болон механик хольцын агуулгыг центрфугийн аргаар тодорхойлох тухай стандарт

12.6.4. ASTM D 4377- Түүхий тосон дахь усны агуулгыг потенциометрийн Карл Фишерийн титрийн аргаар тодорхойлох тухай стандарт

12.6.5. ASTM D 4807- Түүхий тосон дахь усны агуулгыг мембран шүүлтүүрийн аргаар тодорхойлох тухай стандарт

12.6.6. ASTM D 4928- Түүхий тосон дахь усны агуулгыг кулонометрийн Карл Фишерийн титрийн аргаар тодорхойлох тухай стандарт болон бусад холбогдох стандартууд

12.6.7. ASTM Олон улсын байгууллага буюу Америкийн Туршилт болон материалын холбоо нь олон улсын стандартын байгууллага бөгөөд өргөн хүрээний материал, бүтээгдэхүүн, систем, үйлчилгээний техникийн стандартуудыг боловсруулж, хэвлэн нийтэлдэг.

12.7. Хэмжилтийн нэгж, орны нарийвчлал

12.7.1. Газрын тосны бүх төрлийн хэмжилтийг 1,01325 барын агаарын даралтын дор Фаренгейтын жаран (60) хэмийн нөхцөлд шилжүүлэн тооцно.

12.7.2. Хэмжилтийн аливаа нэгжинд олон улсын СИ системийн ангиллыг ашиглана.

12.7.3. Орны нарийвчлалыг дараах хүснэгтэд дурьдсан байдлаар тооцно.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нарийвчлал (таслалын ардах орон)
1	Шингэний хэмжээ	тонн (эсвэл кг) болон баррель	2

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Нарийвчлал (таслалын ардах орон)
2	Цэвэр тосны хэмжээ	тонн (эсвэл кг) болон баррель	2
3	Тухайн үеийн температур	°C	0
4	Нягт	кг/м <sup>3</sup> эсвэл гр/см	3
5	API нягт	-	2
6	Усны агуулга	% эсвэл аравтын бутархай	(3-4)
7	Механик хольц	% эсвэл аравтын бутархай	(3-4)
8	Хүхрийн агуулга	% эсвэл аравтын бутархай	(3-4)
9	15°C хэмд шилжүүлэн тооцсон нягт	кг/м <sup>3</sup> эсвэл гр/см	3
10	15°C хэмд шилжүүлэн тооцсон API нягт	-	2
11	Эзэлхүүний засварын коэффициент (VCF)	аравтын бутархай	(3-4)
12	15°C хэмд шилжүүлэн тооцсон шингэний хэмжээ	килограмм эсвэл тонн	2
13	15°C хэмд шилжүүлэн тооцсон цэвэр тосны хэмжээ	килограмм эсвэл тонн	2

Олон улсын стандартууд, тооцоо, томъёо, нэгж хоорондын хөрвүүлэлт

## 12.8. Хэмжилтийн зөрүү, залруулга

12.8.1. Хэрэв хэмжилтийн цэг дээрх хэмжих төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаа алдагдсан буюу хэмжилт алдаатай хийгдсэн тохиолдолд алдаа гарсан хугацааг хэмжилт алдаатай болсныг мэдсэн өдрөөс өмнө нь хэмжих төхөөрөмжийг хянаж шалгасан өдрийн хоорондох хугацааны дундах өдрөөс эхлэн тооцно.

12.8.2. Гэрээлэгч эсхүл оператор компани хэмжилтийн алдаатай байх үеийн олборлолтын үнэн бодит хэмжээг тогтоож, өмнөх хэмжилтийг залруулах бүхий л арга хэмжээ авна. Гэрээлэгч эсхүл оператор компани нь гүйцэтгэсэн



залруулгын ажлын тухай тайланг газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлж, батлуулна.

12.9. Нэгжийн үнэ, суурь үнэ, /бэнчмарк/, суурь үнийн сонголт, үнийн мэдээллийн эх сурвалж

12.9.1. Нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт газрын тосны тухайн хуанлийн сарын нэгж үнийг дараахь томъёогоор тогтооно.

**$P = B \pm Q - S$**  ам.доллар/баррель.

**B** = Суурь үнэ /бэнчмарк/: Олон улсад өргөнөөр худалдаалагддаг, дэлхийн зах зээлийн үнийг тодорхойлж байдаг, газрын тосны худалдаанд суурь үнэ болгон хэрэглэгддэг ам.доллараар илэрхийлэгдсэн нэгж баррель газрын/түүхий тосны үнэ.

**Q** = Чанараас хамаарсан үнийн тохируулга /API Gravity/:

**S** = Борлуулалтын өртөг

12.9.2. Тухайн суурь үнийн “API Gravity”-ийг гэрээт талбайгаас олборлосон тостой харьцуулан, дээш эсвэл доош байх нэгж “API Gravity” тутамд суурь үнийг “... ам.доллар/баррель”-аар харгалзан нэмэгдүүлэх эсвэл бууруулах үнийн тохируулга.

12.9.3. Тухайн суурь үнийн хүхрийн агууламжийн хувь хэмжээг гэрээт талбайгаас олборлосон тосны хүхрийн агууламжийн хувь хэмжээтэй харьцуулан, дээш эсвэл доош байх нэгж хүхэрийн агууламжийн хувь тутамд суурь үнийг “... ам.доллар/баррель”-аар харгалзан бууруулах эсвэл нэмэгдүүлэх үнийн тохируулга.

12.9.4. Нэгж баррель газрын тосыг борлуулах, тээвэрлэхтэй холбогдон гарах зардлыг тухайн гэрээт талбайн байршил, дэд бүтэц, борлуулалтын боломжоос нь хамааруулан 0-10 ам.доллар/баррель байхаар Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон гэрээлэгч харилцан тохиролцсоны үндсэн дээр тогтооно.

12.9.5. Хэмжилтийн цэгээс хүргэлтийн цэг хүртэлх газрын тосыг ачиж тээвэрлэх, буулгахтай холбоотой зардлыг борлуулалтын өртөг гэнэ.

12.9.6. Нэгж үнийг таслалын дараах 3 орны нарийвчлалаар тооцно.

12.9.7. Борлуулалтын өртөгт өөрчлөлт оруулах асуудлыг Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шийдвэрлэнэ.

12.9.8. Хуанлийн сар бүрийн эцсийн өдөр хүргэлтийн цэг дээр хэмжсэн худалдахаар ачуулсан газрын тосны суурь үнээр тооцно.

12.9.9. Суурь үнийг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрчим хүчний мэдээллийн сүлжээ байгууллагын нийтэлсэн үнээр тогтооно.

12.9.10. Суурь үнийг нийтэлдэг мэдээллийн эх үүсвэрийг Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тогтоох ба шаардлагатай тохиолдолд суурь үнийн сонголтыг Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Гэрээлэгч харилцан тохиролцож болно.

12.9.11. Газрын тосны суурь үнийг дараах дараах томъёогоор тооцно.

$$P = (P_1 + P_2 + \dots + P_n) / n$$

$P_1, P_2, \dots, P_n$  – хуанлийн хугацаанд дэлхийн зах зээл дээр зарлагдсан газрын тосны өдөр бүрийн дундаж үнэ

$n$  - хуанлийн хугацаан дахь ханш зарлагдсан өдрийн тоо

12.9.12. Газрын тосны өдөр тутмын дундаж ханшийг дараах томъёогоор тооцно.

$$(P_1, P_2 + \dots + P_n) = (C_1 + C_2) / 2$$

$P_n$  - Газрын тосны өдөр тутмын дэлхийн зах зээлийн дундаж ханш

$C_1$  – Газрын тосны тухайн өдрийн дэлхийн зах зээлийн нээлтийн ханш

$C_2$  - Газрын тосны тухайн өдрийн дэлхийн зах зээлийн хаалтын ханш

12.10. Газрын тос борлуулах болон тээвэрлэх

12.10.1. Газрын тосны борлуулалт буюу худалдах, худалдан авах гэрээ

Тээврийн гэрээ, хэлцэл, газрын тос борлуулах болон тээвэрлэхтэй холбогдон гарах зардлуудын тодорхойлолт, нэршил, нэгж өртөгийн тооцоолол, томъёолол, өөрчлөлт оруулах

12.11. Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу гэрээлэгчтэй хуваах газрын тосны хуваарилалтын тооцоо, арга аргачлал

12.11.1. Олборлосон тосны хэмжээ

12.11.1.1. Нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт газрын тосны тооцоог олборлосон буюу худалдахаар ачуулсан хуанлийн сар бүр хийнэ.

12.11.1.2. Энэхүү журмын ...-р зүйлд даасны дагуу хэмжилт хийгдсэн олборлосон буюу худалдахаар ачуулсан газрын тосны тухайн хэмжилт нэг бүрийн хувьд олборлосон газрын тосны тоо хэмжээг дараах томъёонуудын аль нэгээр баррель нэгжид шилжүүлэн тооцно. Үүнд:

$$O_{\text{баррель}} = F_{\text{баррель}} * (100\% - W\%)$$

$$O_{\text{баррель}} = F_{\text{тонн}} * (100\% - W\%) * C$$

$$O_{\text{баррель}} = F_{\text{м}^3} * (100\% - W\%) / 0.158987$$

$O_{\text{баррель}}$  – Олборлосон буюу худалдахаар ачуулсан цэвэр газрын/түүхий тосны тоо хэмжээ /баррелиар/

$F_{\text{баррель}}$  – Энэхүү журмын 7.5.1.2-р зүйлд заасны дагуу хэмжсэн олборлосон буюу худалдахаар ачуулсан шингэний тоо хэмжээ /баррелиар/

$F_{\text{тонн}}$  – Энэхүү журмын ...-р зүйлд заасны дагуу хэмжсэн олборлосон буюу худалдахаар ачуулсан шингэний тоо хэмжээ /тонноор/

$F_{\text{м}^3}$  – Энэхүү журмын ...-р зүйлд заасны дагуу хэмжсэн олборлосон буюу худалдахаар ачуулсан шингэний тоо хэмжээ /метр кубээр/

$W\%$  – Энэхүү журмын ...-р зүйлд заасны дагуу хэмжсэн шингэн дэх ус болон бусад элементийн нэгдлийн агууламжийн хувь хэмжээ /хувиар/

$C$  – Энэхүү журмын ...-р зүйлд заасны дагуу хэмжиж, тооцсон тонн-баррелийн харьцаа /ко-эффицентээр/

12.11.1.3. Хэмжилт нэг бүр гэж олборлосон газрын тосыг агуулсан вагон, цистерн, авто машин бүрээр эсхүл хэсэгчилсэн бүлэг цувааг хэлнэ.

12.11.1.4. Олборлосон газрын тосны тоо хэмжээг таслалын дараах 3 орны нарийвчлалаар тооцно.

12.11.1.5. Хуанлийн сард нийт олборлосон газрын тосны тоо хэмжээг дээрх томъёоны дагуу тухайн сард олборлосон буюу худалдахаар ачуулсан газрын тосны хэмжилт нэг бүрийн нийлбэрээр тооцно.

12.11.2. Нөөц ашигласны төлбөрийн үнэлгээ, тооцоо

12.11.2.1. Хуанлийн сард нийт олборлосон буюу худалдахаар ачуулсан газрын тосонд ногдуулах нөөц ашигласны төлбөрийг дараах томъёогоор тооцно.

$$GR = GO_{\text{баррель}} * P * R\% \text{ ам.доллар}$$

$GR_{\text{баррель}}$  – Нөөц ашигласны төлбөр

$GO_{\text{баррель}}$  – Хуанлийн сард нийт олборложсон буюу худалдахаар ачуулсан цэвэр тосны хэмжээ /баррелиар/

$P$  – Энэхүү журмын ...-т заасан нэгж баррель газрын/түүхий тосны үнэ /ам.доллараар/

**R%** – Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан олборлосон газрын тосонд ногдуулах нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээ /хувиар/

12.11.3. Өртөгт газрын тосны үнэлгээ, хэмжээ

12.11.3.1. Хуанлийн сард нийт олборлосон буюу худалдахаар ачуулсан газрын тосон дахь Гэрээлэгчийн өртөгт газрын тосны тоо хэмжээг дараах томъёогоор тооцно.

**CO = (GO<sub>баррель</sub> \* P – GR) \* CR%** ам.доллар

**CO** - Өртөгт газрын тосны тоо хэмжээ

**GO<sub>баррель</sub>** – Энэхүү журмын ...-т заасны дагуу тооцсон хуанлийн сард нийт олборлосон буюу худалдахаар ачуулсан цэвэр газрын/түүхий тосны хэмжээ /баррелиар/

**P** – Энэхүү журмын ...-т заасан хуанлийн сарын нэгж баррель газрын/түүхий тосны үнэ /ам.доллараар/

**GR** – Энэхүү журмын 7.5.2-т заасны дагуу тооцсон нөөц ашигласны төлбөрийн тоо хэмжээ /ам.доллараар/

**CR%** – Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан өртөгт газрын тосны хувь хэмжээ /процентоор/

12.11.3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь нийт өртөг нөхөгдөх зардлаа нөхөж дуустал үлдэгдлийг дараагийн хуанлийн саруудад шилжүүлэн тооцно.

12.11.3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өртөг нөхөгдөх зардлын үлдэгдэл тухайн хуанлийн сард нөхөн авах өртөгт газрын тосны хэмжээнээс бага байвал зөрүүг ашигт газрын тос гэж үзэж бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу хуваарилна.

12.11.3.4. Бүтээгдэхүүн хуваах гэрээ дуусгавар болох эсхүл гэрээлэгчийн хүсэлтээр цуцлах тохиолдолд өртөг нөхөгдөх зардлаас нөхөгдөөгүй үлдсэн хэсгийг гэрээлэгчид олгохгүй.

12.11.4. Ашигт газрын тосны үнэлгээ, тооцоо

12.11.4.1. Хуанлийн сард нийт олборлосон буюу худалдахаар ачуулсан газрын тосон дахь ашигт газрын тосны тоо хэмжээг дараах томъёогоор тооцно.

**PO = GO<sub>баррель</sub> \* P – GR – CO** ам.доллар

**PO** - Ашигт газрын тосны тоо хэмжээ

**GO**баррель – Энэхүү журмын ...-т заасны дагуу тооцсон хуанлийн сард нийт олборлосон буюу худалдахаар ачуулсан цэвэр газрын/түүхий тосны хэмжээ /баррелиар/

**P** – Энэхүү журмын ...-т заасан хуанлийн сарын нэгж баррель газрын/түүхий тосны үнэ /ам.доллараар/

**GR** – Энэхүү журмын ...-т заасны дагуу тооцсон нөөц ашигласны төлбөрийн тоо хэмжээ /ам.доллараар/

**CO** – Энэхүү журмын ...-т заасны дагуу тооцсон өртөгт газрын тосны тоо хэмжээ /ам.доллараар/

12.11.5. Бүтээгдэхүүн хуваалтын үнэлгээ, тооцоо

12.11.5.1. Хуанлийн сарын ашигт газрын тосны Монгол Улсын Засгийн газар болон Гэрээлэгчид ногдох тоо хэмжээг дараах томъёогоор тооцно.

**MS = PO \* M%** ам.доллар

**CS = PO \* N%** ам.доллар

**MS** – Ашигт газрын тосны Монгол улсын Засгийн газарт ногдох газрын тосны орлого /ам.доллараар/

**M%** – Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан ашигт газрын тосны Монгол улсын Засгийн газарт ногдох хувь хэмжээ /процентоор/

**CS** – Ашигт газрын тосны Гэрээлэгчид ногдох газрын тосны орлого /ам.доллараар/

**N%** – Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан ашигт газрын тосны Гэрээлэгчид ногдох хувь хэмжээ /процентоор/

12.11.5.2. Бүтээгдэхүүн хуваалтын хувь хэмжээ нь гэрээт талбайн тухайн хуанлийн сарын газрын тосны дундаж олборлолтын хэмжээнээс хамааран Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасны дагуу харилцан өөр өөр байна.

12.11.6. Хуваарилалтын тооцоог газрын тосоор хийх тохиолдол

12.11.6.1. Монгол Улсын Засгийн газар нь нөөц ашигласны төлбөр болон ашигт газрын тосны өөрт ногдох хувийг газрын тосоор авч болно. Тосоор авах тохиолдолд энэ тухай Тусгай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэнэ.

12.11.6.2. Монгол Улсын Засгийн газар нь нөөц ашигласны төлбөр болон ашигт газрын тосны өөрт ногдох хувийг газрын тосоор авах тохиолдолд нөөц

ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт газрын тос, бүтээгдэхүүн хуваалтыг дараах томъёогоор тооцно.

Нөөц ашигласны төлбөрт ногдох газрын тосны хэмжээ:

$$GR_{\text{баррель}} = GO_{\text{баррель}} * R\% \text{ баррель}$$

Өртөгт газрын тосны хэмжээ, үнэлгээ, тооцоо:

$$CO_{\text{баррель}} = (GO_{\text{баррель}} - GR_{\text{баррель}}) * CR\% \text{ баррель}$$

$$CO = (GO_{\text{баррель}} - GR_{\text{баррель}}) * P * CR\% \text{ ам.доллар}$$

Ашигт газрын тосонд ногдох газрын тосны хэмжээ:

$$PO_{\text{баррель}} = GO_{\text{баррель}} - GR_{\text{баррель}} - CO_{\text{баррель}} \text{ баррель}$$

Бүтээгдэхүүн хуваалтын хэмжээ:

$$MS_{\text{баррель}} = PO_{\text{баррель}} * M\% \quad \text{баррель (МУЗГ-т ногдох газрын тос)}$$

$$CS_{\text{баррель}} = PO_{\text{баррель}} * N\% \quad \text{баррель (Гэрээлэгчид ногдох газрын тос)}$$

12.11.7. Тооцооны зөрүүг тодруулах, залруулга хийх

Тооцооны зөрүүг тодруулах, тайланг засварлаж дахин ирүүлэх, зөрүүний баталгаажуулалт

12.11.8. Хугацааны алданги болон нөхөн төлбөр ногдуулах

## АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТАЙЛАН, МЭДЭЭ

13.1 Ерөнхий

13.1.1. Компани нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу санхүүгийн тайланг бэлтгэж, тодруулна.

13.1.2. Гэрээлэгч эсхүл оператор компани нь газрын тосны хайгуул, ашиглалт, бүтээн байгуулалт, татан буулгалтын үйл ажиллагаанд хамаарах нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль тогтоомж болон энэхүү гэрээний дагуу монгол хэл дээр, шаардлагатай гэж үзвэл монгол, англи хэл дээр давхар хөтөлнө;

13.1.3. Гэрээлэгч эсхүл оператор компани нь хөрөнгө оруулалт, борлуулалтын орлоготой холбоотой гүйлгээг Монгол Улсад бүртгэлтэй

арилжааны банкаар дамжуулан гүйцэтгэх бөгөөд уг гүйлгээг санхүүгийн тайланд ил тод, нээлттэй бүрэн тусгана.

13.1.4. Гэрээлэгч эсхүл оператор компани нь санхүүгийн тайлан, өртөг нөхөгдөх зардлын тайлан болон нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт газрын тосны хуваалтын тооцооны тайланг зохих журмын дагуу төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ;

13.1.5. Гэрээлэгч эсхүл оператор компани нь энэхүү журмын 12.3.-д заасан тайлан болон холбогдох бүх баримт бичгийг анх байгуулагдсан өдрөөс хойш 5 (тав) жил эсхүл хууль тогтоомжид заасан хугацаанд хадгалах бөгөөд газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шаардлагатай тохиолдолд эдгээр материалтай танилцаж болно.

13.2 Өртөг нөхөгдөх зардлын тайланг хүргүүлэх хугацаа:

13.2.1 Гэрээлэгч эсхүл оператор компани нь хайгуул, ашиглалтын хугацаанд дараах тайланг төрийн захиргааны байгууллага болон холбогдох төрийн байгууллагад хүргүүлнэ.

13.2.2 Хайгуулын хугацаанд хуанлийн улирал дууссанаас 20 (хорь) хоногийн дотор, жилийн эцсийн хувьд дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор:

13.3 Санхүүгийн тайлан, нэмэлт тодруулгууд

13.3.1 Өртөг нөхөгдөх зардлын тайлан

13.3.2 Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан (өртөг нөхөгдөх зардалд тооцогдсон эсэхийг тэмдэглэнэ)

13.3.3 Бараа материалын дэлгэрэнгүй тайлан (өртөг нөхөгдөх зардалд тооцогдсон эсэхийг тэмдэглэнэ)

13.3.4 Ашиглалтын хугацаанд хуанлийн сар бүр дууссанаас хойш 20 (хорь) хоногийн дотор:

13.3.5 Газрын тосны олборлолт, ашиглалт, борлуулалтын тайлан

13.3.6 Борлуулалтын орлого, зардал, Нөөц ашигласны төлбөр, өртөгт газрын тос, ашигт газрын тосны тооцоо тайлан

13.3.7 Хуанлийн улирал бүр дууссанаас 20 (хорь) хоногийн дотор, жилийн эцсийн хувьд дараа оны 2 дугаар сарын 10-ны өдрийн дотор:

13.3.8 Санхүүгийн тайлан, тодруулгууд

13.3.9 Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан (өртөг нөхөгдөх зардалд тооцогдсон эсэхийг тэмдэглэнэ)

13.3.10 Бараа материалын дэлгэрэнгүй тайлан (өртөг нөхөгдөх зардалд тооцогдсон эсэхийг тэмдэглэнэ)

13.3.11 Өртөг нөхөгдөх зардлын тайлан

13.3.12 Захиргааны зардлын тайлан

13.3.13 Өртөг нөхөгдөх зардлын тайланг Газрын тосны тухай хууль, БХГ-д заасан ангилалын (энэхүү журмын хавсралт маягт №....) дагуу зардал тус бүрээр дэлгэрэнгүй тайлагнана.

#### АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ХЯНАЛТ, ШАЛГАЛТ

14.1 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь гэрээлэгч эсхүл оператор компанийн Монгол Улсын хууль тогтоомж, бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан төлбөр, урамшууллын төлөлт, орлогын тооцоо болон газрын тостой холбогдсон үйл ажиллагааны зардлыг үнэн зөв бүртгэж, тайлагнасан байдалд байнгын хяналт тавьж ажиллана.

14.2 Төрийн аудитын байгууллага нь газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай хамтарсан ажлын хэсэг байгуулж, гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг хянан баталгаажуулна.

14.3 Хяналт, шалгалтыг батлагдсан төлөвлөгөө, төсвийн дагуу хийж гүйцэтгэсэн ажил, санхүүгийн тайлан, нэмэлт тодруулга, холбогдох бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болон газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын байнгын хяналтын холбогдох баримт материалд үндэслэн жил бүр хийнэ.

14.4 Ажлын хэсэг хяналт, шалгалтын дүгнэлтийн төслийг гэрээлэгч эсхүл оператор компанид хүргүүлнэ.

14.5 Гэрээлэгч эсхүл оператор компани нь шалгалтын дүгнэлтийн төслийг хүлээн авснаас хойш ажлын 7 хоногт баталгаажуулж, ажлын хэсэгт ирүүлнэ.



14.6 Хэрэв гэрээлэгч эсхүл оператор компани нь хяналт, шалгалтын дүгнэлтийн төслийг хүлээн зөвшөөрөхгүй бол тайлбарыг ажлын 7 хоногийн дотор тайлбар, холбогдох нотлох баримтын хамт өгөх эрхтэй бөгөөд ажлын хэсэг тайлбар, нотлох баримтыг судлан дүгнэлт тайланд засвар оруулах үндэслэлгүй гэж үзвэл өөрсдийн гаргасан дүгнэлтээр эцэслэн баталгаажуулна.

14.7 Санхүүгийн хяналт, шалгалтын дүгнэлтийг гэрээлэгч эсхүл оператор компани нь хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлоо холбогдох хууль журмын дагуу шийдвэрлүүлж болно.

14.8 Бүтээгдэхүүн хуваах гэрээний хүрээнд гэрээлэгч эсхүл оператор компанийн үйлдвэрлэлийн байр, байгууламж, агуулах болон албан контортой очиж танилцаж холбогдох албан тушаалтнаас шаардлагатай баримт материалыг гаргуулан авна.

14.9 Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь санхүүгийн хяналт, шалгалт эхлэхээс ажлын арваас (10) доошгүй хоногийн өмнө санхүүгийн хяналт, шалгалт хийх тухай гэрээлэгч эсхүл оператор компанид мэдэгдэнэ.

14.10 Гэрээлэгч эсхүл оператор компани нь санхүүгийн хяналт, шалгалт явуулахад шаардлагатай бэлтгэл ажлыг бүрэн хангасан байна.

14.11 Санхүүгийн хяналт шалгалттай холбогдон гарах зардлыг гэрээлэгч эсхүл оператор компани хариуцна.

#### АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ, ХАРИУЦЛАГА

15.1. Газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны явцад үүсэх эд хөрөнгийн болон бусад маргааныг талууд хэлэлцээрийн журмаар шийдвэрлэх эрхтэй. Хэлэлцээрийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд талууд гомдлоо шүүх эсхүл арбитраж гаргаж болно.

15.2. Энэхүү гэрээтэй холбогдон гарсан аливаа маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хянан шийдвэрлэнэ.

15.3. Гэрээлэгч эсхүл оператор газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааны тодорхой хэсгийг гүйцэтгүүлэхээр туслан гүйцэтгэгч сонгосон тохиолдолд тухайн туслан гүйцэтгэгчийн үйл ажиллагааны улмаас учирсан бүх хохирлыг Монгол Улсын Засгийн газрын өмнө гэрээлэгч эсхүл оператор хариуцна.

15.4. Гэрээлэгч эсхүл оператор нь энэхүү гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй болон хууль тогтоомжийг зөрчсөн бол Газрын тосны тухай хуулийн 44 дүгээр зүйл болон Зөрчлийн тухай хуулийн 7.13 дугаар зүйлд заасны дагуу хариуцлага хүлээнэ.

---o-O-o---

ХАВСРАЛТ №1 ГЭРЭЭЛЭГЧ ЭСХҮЛ ОПЕРАТОР КОМПАНИЙН ГАЗРЫН ТОСНЫ  
АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГАД ИРҮҮЛЭХ  
МАЯГТУУД